



SWEDISH ENVIRONMENTAL
PROTECTION AGENCY

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗАСАГЛАЛ ТӨСӨЛ

Уул уурхайн салбарын засаглалд байгаль орчин, хүний эрхийн зарчмыг тусгах нь



Монгол улс 2020-2023

Төслийн үр нөлөөний тойм үнэлгээ

УЛААНБААТАР 2024

Ерөнхий мэдэгдэл

Энэхүү гарын авлагын агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд НҮБХХ-ийн болон Шведийн Байгаль Хамгаалах Агентлагын албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй. Энэхүү бүтээгдэхүүнд ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт НҮБХХ хариуцлага хүлээхгүй болно. Энэхүү баримт бичигт тодорхой нутаг дэвсгэр, газарзүйн бүсийг нэрлэхдээ "улс" гэсэн нэр томъёог ашигласан нь ямарваа нэгэн газар нутгийн эрх зүйн болон бусад статусын талаарх үзэл бодол, утга агуулгыг илэрхийлээгүй болно.

НҮБХХ-ийн тухай

НҮБХХ нь ядуурал, тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шударга бус байдлыг эцэслэх зорилго бүхий НҮБ-ын тэргүүлэх байгууллага юм. Дэлхийн 170 орны түншлэгчид болон мэргэжилтнүүдийн өргөн цар хүрээт хамтын ажиллагааны дүнд эх дэлхий, хүн бүрийн сайн сайхны төлөө хөгжлийн урт хугацааны, цогц шийдлийг бий болгоход улс үндэстнүүдийг дэмжин ажилладаг.

Дэлгэрэнгүйг undp.org/mongolia эсвэл [@UNDP Mongolia](https://twitter.com/UNDP Mongolia) хаягаар авна уу.

Холбоо барих хаяг:

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, НҮБ-ын Байр, Нэгдсэн Үндэстний Гудамж -14,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201, Монгол Улс, Утас: + 976-11-327585



SWEDISH ENVIRONMENTAL
PROTECTION AGENCY



БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗАСАГЛАЛ ТӨСӨЛ

Уул уурхайн салбарын засаглалд байгаль орчин, хүний эрхийн зарчмыг тусгах нь

Монгол улс 2020-2023 Төслийн үр нөлөөний тойм үнэлгээ

Шведийн Байгаль Хамгаалах Агентлагийн санхүүгийн дэмжлэгээр НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс хөгжиж буй зорилтот 10 орны уул уурхайн салбарын засаглалыг сайжрууах зорилгоор байгаль орчин, хүний эрхийг хамгаалах хууль эрх зүйн орчин, түүний хэрэгжилт, хариуцлага, хяналтын тогтолцоог боловсронгуй болгон бэхжүүлэх, талуудын олон талт хамтын оролцоог дэмжихэд чиглэсэн энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэв.

УЛААНБААТАР 2024

ТАЙЛАН БИЧСЭН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

Байгаль орчны засаглал хөтөлбөрийн II үе шат буюу 2020-2023 онуудад хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр нөлөөний тойм үнэлгээний тайланг уул уурхайн салбарын нийгэм, байгаль орчин, засаглалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Монголын тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын зөвлөл (ТНЗ) ТББ-ын Үүсгэн байгуулагч О.Батболд, Гүйцэтгэх захирал Н.Ариунтуяа нар боловсрууллаа.

Уул уурхайн засаглалын судлаач Отгонбаярын Батболд

О.Батболд нь ХБНГУ-ын Мюнстерийн их сургуульд улс төр судлал, социологи, харилцааны шинжлэх ухааны магистрт суралцсан. Тэрээр Германы Бундестагийн Байнгын хороо, Гишүүний Ажлын алба, Тогтвортой хөгжлийн төлөөх хариуцлагатай уул уурхайн санаачилга, Герман-Монголын Бизнес эрхлэгчдийн холбоо, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ) зэрэг байгууллагад Герман, Камбож болон Монгол Улсад ажилласан туршлагатай.

2018 онд Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн Камбож Улс дахь Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөрийн Ахлах зөвлөхөөр томилогдох хүртлээ Монгол Улс дахь GIZ-ийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага хөтөлбөрийн мэргэжилтэн, ахлах зөвлөх, дэд захирлаар 8 жил ажилласан.

2020 оноос ХБНГУ-ын Шпайрын Их сургуульд Уул уурхай ба орон нутаг-Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулах нь сэдвээр докторын судалгаа хийж байна. Тэрээр 2019 оны нэгдүгээр сараас Монголын тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын зөвлөл (ТНЗ)-ийн Удирдах зөвлөлийн даргаар сонгогдон ажиллаж байна.

Сэтгүүлч Номинхүүгийн Ариунтуяа

Н.Ариунтуяа нь уул уурхай, эдийн засгийн чиглэлээр мэргэшсэн сэтгүүлч бөгөөд 2010-2018 онд Монголын уул уурхайн анхны төрөлжсөн сэтгүүл Mongolian Mining Journal сэтгүүлд Орлогч эрхлэгч, Эрхлэгчээр ажилласан. Мөн 2021 оноос "Mining Insight" сэтгүүлийг хамтран үүсгэн байгуулж, Гүйцэтгэх захирал, Ерөнхий эрхлэгчээр ажиллаж байна.

Тэрээр "New Tech, New Deal" төслийн захиалгаар хийсэн "Монголын уул уурхайн салбар дахь технологийн чиг хандлага, үр нөлөө" судалгааны судлаачаар, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн олон улсын байгууллагын тэтгэлгээр "Шилэн дансны мэдээлэлд дүн шинжилгээ хийх" төслийн удирдагчаар ажилласан. Ашигт малтмал, газрын тосны газрын "Жилийн тайлан-2017" товхимолын редактор, Өмнөговь аймгийн төсвийн зарцуулалтад хийсэн дүн шинжилгээнд үндэслэсэн "Иргэн та уул уурхайгаас ямар ашиг хүртэх вэ?" комикс номын зохиогч.

Тэрээр 2019 оны нэгдүгээр сараас Монголын тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын зөвлөл (ТНЗ)-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

Зохиогчид өөрсдийн мэдлэг ойлголт, туршлагадаа тулгуурлан дүн шинжилгээ хийсний үндсэн дээр энэхүү тойм тайланг боловсруулав. Тэдний үзэл бодол, тайлбар нь оролцогч бүхий л талын санаа бодол, байр суурийг илэрхийлэх албагүй гэдгийг анхаарах нь чухал юм. Энэхүү тайлангийн танилцуулга нь зөвхөн мэдээллийн зорилго агуулж буй тул уншигчид өөрсдийн дүгнэлтийг хийж, шаардлагатай бол нэмэлт мэдээллийг лавшруулан судлахыг зөвлөж байна. Тайлангийн зохиогчид энэхүү тайлангийн агуулгад үндэслэн гаргасан шийдвэр, аливаа үйлдэлд хариуцлага хүлээхгүй. Түүнчлэн тус тайлан нь тодорхой хөтөлбөр, ашиг сонирхлыг дэмжин сурталчлахаас зайлсхийж, тэнцвэртэй, мэдээлэлтэй үнэлгээ өгөхийг зорьсон болно.

Зургийг: П.Жаргалсайхан, Р.Ариунбилэг, Ч.Энхжаргал, Н.Баярсайхан

1. ХӨТӨЛБӨРИЙН ТОЙМ.....	4
1.1 Оршил	5
1.2 Хөтөлбөрийн зорилго	5
1.3 Үндсэн үйл ажиллагаа.....	6
2. ХӨТӨЛБӨРИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ.....	8
2.1 Хамтрагч байгууллагуудын тухай.....	9
2.2 Өөрчлөлт оруулсан эрх зүйн баримт бичиг	10
2.3 Боловсруулсан гарын авлага, аргачлалууд.....	11
2.4 Чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа	13
2.5 Ашиг тус хүртэгчдийн талаарх мэдээлэл	14
3. ҮР ДҮНГИЙН МЭДЭЭЛЭЛ (ТООН БОЛОН ЧАНАРЫН).....	16
4. КЕЙС СУДАЛГАА	20
4.1 Кейс судалгаа 1: Эрдэс баялгийн салбарт Хүний Эрхийн Магадлан Шинжилгээ хийх аргазүйг нэвтрүүлсэн нь	21
4.2 Кейс судалгаа 2: Хариуцлагатай уул уурхайн жишиг шаардлага ба үнэлгээний аргачлалыг уул уурхайн компаниудад нэвтрүүлсэн нь	25
4.3 Кейс судалгаа 3: Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон газарт нөхөн сэргээлт хийх аргачлал боловсруулж, нэвтрүүлсэн нь.....	28
4.4 Кейс судалгаа 4: Хамтын оролцоотой байгаль орчны мониторингийн механизмыг түгээн дэлгэрүүлэх нь	31
4.5 Кейс судалгаа 5: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль эрхзүйн орчныг боловсронгуй болгон, дэд бүтцийн төсөлд нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх эрхзүйн орчныг бий болгосон нь.....	35
5. ДҮГНЭЛТ	39
5.1 Сургамж, хүндрэл бэрхшээл	39
5.2 Дүгнэлт	39
5.3 Зөвлөмж	40
5.4 Төслийн дараагийн шатанд өгөх зөвлөмж.....	40

ТОВЧИЛСОН ҮГС

ААН	Аж ахуйн нэгж
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОЗ	Байгаль орчны засаглал
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОНБУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
ГХЯ	Гадаад харилцааны яам
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУУҮА	Монголын уул уурхайн үндэсний ассоциаци
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ННҮ	Нийгмийн нөлөөллийн үнэлгээ
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ТТАМ	Түгээмэл тархацтай ашигт малтмал
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХОБОМ	Хамтын оролцоотой байгаль орчны мониторинг
ХЭМШ	Хүний эрхийн магадлан шинжилгээ
ХЭНБМШ	Хүний эрхэд нөлөөлөх байдлын магадлан шинжилгээ
ХЭНБҮ	Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ЭБЭХ	Эрдэс баялаг эмэгтэйчүүдийн холбоо

ХАВСРАЛТУУД

- Хавсралт 1.** Б03 төслийн хүрээнд хийсэн судалгаа, үнэлгээний ажлын жагсаалт
- Хавсралт 2.** Б03 төслийн хүрээнд боловсруулан гаргасан гарын авлага, аргачлал, сургалтын материалуудын жагсаалт
- Хавсралт 3.** Б03 төслийн үйл ажиллагааны тайлангуудын жагсаалт

1. ХӨТӨЛБӨРИЙН ТОЙМ



“Эмэгтэйчүүд ба уул уурхайн ирээдүй” Монгол Улсын судалгааны тайлангаас, 2022

1.1 Оршил

Монгол Улсын эдийн засагт эрдэс баялгийн салбар голлох үүрэг гүйцэтгэж байна. Экспортын чиг баримжаатай эдийн засгийг дэмжих төрийн бодлогын хүрээнд эрдэс баялгийн салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбараар тодорхойлсон бөгөөд 2009-2012 онд уул уурхайн үйлдвэрлэлийн өгөөж хамгийн өндөр өсөлттэй байв. Тэрхүү өндөр өсөлт буурсан хэдий ч уул уурхайн салбарын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл өндөр, түүнийг дагаад хүний эрх, хууль дээдлэх зарчимд нийцсэн байгалийн нөөцийн тогтвортой удирдлагыг хангах байгаль орчны засаглалын асуудал сорилттой хэвээр байна.

Монгол Улсын хувьд байгаль орчны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх тогтолцоо хангалттай сайн бэхжээгүй байгаа нь уул уурхайн үйл ажиллагааны явцад хүний эрх, хууль дээдлэх зарчмууд зарим тохиолдолд зөрчигдөхөд хүрч байна. Тэр дундаа эрдэс баялгийн салбарын шийдвэр гаргах үйл явцад төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, орон нутаг зэрэг оролцогч талуудын тэгш оролцоо сул, хамтын ажиллагааны хүчин чармайлт хангалттай биш хэвээр байна. Байгаль орчны менежментийн арга хэрэгслийн талаарх мэдлэг, чадавх хангалтгүй байгаа нь уул уурхайн салбарын байгалийн нөөцийн тогтвортой удирдлагад шаардлагатай байгаль орчны үр дүнтэй засаглалыг хэрэгжүүлэхэд оролцогч талуудад саад болж байна.

Эдгээр тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс Шведийн Байгаль Хамгаалах Агентлагийн санхүүгийн дэмжлэгээр уул уурхайн салбарт байгаль орчныг хамгаалах, хүний эрхийг хангах хууль эрх зүйн тогтолцоо, хэрэгжилтийн механизмыг сайжруулах, талуудын хамтын оролцоо, хариуцлагын зарчим, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэсэн Байгаль орчны засаглал хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. Монгол Улс энэхүү хөтөлбөрийн зорилтот хөгжиж буй 10 орны нэг бөгөөд эхний үе шат нь 2018-2020 он, хоёр дахь үе шат 2020-2023 онд хэрэгжээд байна.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Байгалийн нөөцийн тогтвортой удирдлагыг хангах Байгаль орчны засаглал хөтөлбөр нь Шведийн Байгаль Хамгаалах Агентлаг болон НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн хамтын санаачилга юм. Энэхүү хөтөлбөр нь байгаль орчны болон хүний эрхийн зарчмуудыг эрдэс баялгийн салбарын засаглалын тогтолцоонд нэвтрүүлэхэд нь зорилтот орнуудад туслах зорилготой. Олон улсын болон бүс нутгийн түвшинд хэрэгждэг тус хөтөлбөр улс орон, бүс нутгуудын хооронд бодлогын шинэлэг арга барил, туршлага солилцоход мөн дэмжлэг үзүүлэх зорилго агуулдаг.

Байгаль орчны засаглал хөтөлбөрийн үндсэн зорилго нь байгалийн нөөцийн тогтвортой удирдлагыг хангах цогц шийдлийг тодорхойлж, хэрэгжүүлэх явдал бөгөөд үл ойлголцол, зөрчилдөөн, байгаль орчны доройтол, тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалт, ядуурал зэрэг асуудлын үндсэн шалтгааныг арилгах замаар байгаль орчныг хамгаалах, хүний эрхийг хүндэтгэхийн чухлыг онцолж байна.

БОЗ хөтөлбөр нь дараах үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулсан байна. Үүнд:

1. Уул уурхайн салбарын бодлого, хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох
2. Хэрэгжүүлэх, мөрдөх чадавхыг бэхжүүлэх
3. Олон нийтийн оролцооны илүү сайжруулсан механизм бий болгох
4. Жендэрийн тэгш байдлыг хангасан шинэлэг үйл явц нэвтрүүлэх
5. Олон талт талбарыг сайжруулах
6. Бизнесийн үйл ажиллагаанд магадлан шинжилгээний шинэ санаачилгуудыг хэрэгжүүлэх

Байгаль орчны засаглал хөтөлбөр нь эдгээр чиглэлд зорилтот улс орнууд, тэр дундаа Монгол Улсад байгалийн нөөцийн менежментийн цогц бөгөөд тогтвортой хандлагыг төлөвшүүлэхийг дэмжих, байгаль орчин болон хүний эрхийг хамгаалахад үйл ажиллагаагаа чиглүүлсэн байна.

1.3 Үндсэн үйл ажиллагаа

2020-2023 онд хэрэгжсэн Байгаль орчны засаглал төслийн хоёр дахь үе шатанд хууль эрх зүйн орчинд цөөнгүй өөрчлөлт санал болгож, оролцогч талуудаар хэлэлцүүлэн дэмжлэг авчээ. Мөн чадавхжуулах сургалт, семинарууд олноор зохион байгуулж, холбогдох төлөөллүүдийг хамруулсан байна. Хөтөлбөрийн Монгол дахь үйл ажиллагаа дараах зургаан үндсэн чиглэлтэй бөгөөд эдгээрийн хүрээнд 7 томоохон судалгаа, үнэлгээ (Хавсралт 1) хийж, холбогдох гарын авлага, зааврыг (Хавсралт 2) боловсруулжээ. Үүнд:

1.3.1 Байгаль орчны хууль эрх зүйн орчныг сайжруулах, уул уурхайн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, хүний эрхийн зарчмуудыг сахин хамгаалах механизмыг бэхжүүлэх хүрээнд иж бүрэн үнэлгээ, суурь судалгааны ажлууд хийж, судалгааны үр дүн, дүгнэлтийг оролцогч талуудад танилцуулсан байна. Цаашлаад Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлж, иргэд, салбарын мэргэжилтнүүд, бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдад чиглэсэн нөлөөллийн ажил зохион байгуулсан байна. Үүний зэрэгцээ дэд бүтцийн төслүүдэд хийх нийгмийн нөлөөллийн үнэлгээг олон улсын чиг хандлагад нийцүүлсэн өөрчлөлтийг БОНБУ-ний журамд шинээр тусгуулан, салбарын оролцогч талуудад танилцуулсан байна.

1.3.2 Талуудын хамтын ажиллагаа, хариуцлагатай оролцоог төлөвшүүлэх хүрээнд уул уурхайн төслүүдэд иргэдийн хамтын оролцоотой байгаль орчны мониторинг (ХОБОМ) хийх удирдамжийг боловсруулан таван аймагт нэвтрүүлээд байна.

1.3.3 Хариуцлагатай уул уурхайн зарчмыг дэмжих хүрээнд Хариуцлагатай уул уурхайн жишиг шаардлагыг гаргаж, түүнд суурилсан “Хариуцлагатай уул уурхайн хөтөлбөр”, “Хариуцлагатай уул уурхайн кодекс”-ийг салбарын мэргэжлийн холбоотой хамтран боловсруулж, нэвтрүүлж эхэлснээр уул уурхайн 38 компани Хариуцлагатай уул уурхайн кодексыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр ажиллаж байна.

- 1.3.4** Уул уурхайн салбарт хүний эрхийн зөрчлийг бууруулах, улмаар арилгах үндсэн зорилгын хүрээнд нүүрсний уурхайнуудад хүний эрхэд үзүүлэх нөлөөллийг үнэлэх удирдамж боловсруулан хэрэгжүүлсэн байна. Мөн НҮБ-ын Бизнес ба Хүний эрхийн удирдах зарчмуудын дагуу уул уурхайн компаниудын үйл ажиллагаанд Хүний эрхийн магадлан шинжилгээ (ХЭМШ)-г жишиг болгон хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлжээ.
- 1.3.5** Уул уурхайн үйл ажиллагаанаас үүссэн газрын эвдрэл, орхигдсон газрыг нөхөн сэргээх хүрээнд уул уурхайн үйл ажиллагаанд өртсөн талбайн тооллого хийхэд сургалтын болон техникийн дэмжлэг үзүүлжээ. Түүнчлэн түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон газарт нөхөн сэргээлт хийх хялбаршуулсан аргачлал, зааварчилгааг боловсруулсан нь ТТАМ олборлогчдын хувьд үр дүнтэй ажил болсон байна. Улмаар нөхөн сэргээлтийн үзүүлэх сургалт зохион байгуулж, аж ахуйн нэгжүүдээс гадна мэргэжлийн хяналтын байгууллагын төлөөллийг өргөнөөр оролцуулжээ.
- 1.3.6** Байгалийн нөөцийн менежментийг сайжруулахад голлох оролцогч талуудын чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн техникийн заавар, арга зүйн удирдамжийг боловсруулж талуудад танилцуулсан байна. 2020 онд “Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтад хүний эрх, хууль дээдлэх зарчмыг хангах нь: Байгаль орчны холбогдолтой зөрчлийн хэргийг шалгах аргачлал”-ыг 500 хувь хэвлэн, мэргэжлийн хяналтын улсын байцаагч нарт хүргүүлжээ. Эдгээр гарын авлагыг төв, орон нутгийн байцаагчдад тарааж, цахим хувилбарыг НҮБХХ-ийн цахим хуудсанд байршуулсан байна.



Зураг 1. Нөхөн сэргээлтийн талбайд малын хөлөөр ургамлын үр суулгах үзүүлэх сургалт, Очиртням уурхайн талбай, 2021 он

2. ХӨТӨЛБӨРИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ



Монгол-Киргиз хоёр улсын уул уурхайн салбарын байгаль орчны засаглалд оролцогч талуудын туршлага солилцох хөтөлбөрийн үеэр оролцогчид Төв аймгийн Баянжаргалан сумын ХОБОМ-ийн мониторингийн цэгт, 2023

2.1 Хамтрагч байгууллагуудын тухай

Байгаль орчны засаглал төслийн хоёрдугаар шатанд Монгол Улсын яамд, төрийн байгууллагууд, орон нутгийн ЗДТГ, мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгжүүд, төрийн бус байгууллага зэрэг гол түншүүдтэй хамтран ажиллахад онцгой ач холбогдол өгч, үндэсний хэмжээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлсэн байна.

- Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран БОНБУ-ний одоогийн тогтолцоо, хэрэгжүүлэх механизмын бүтээмжийн үнэлгээ, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиудад шаардлагатай өөрчлөлтүүдийг нэмж тусгахтай холбоотой судалгаа, хууль тогтоомжийн өөрчлөлт хийхтэй холбоотой бодлогын зөвлөмж, БОНБУ хийх төслүүдийн ангиалалыг шинэчлэх санал боловсруулж, түүнтэй холбоотой гарах зардлын тооцооллыг хийжээ.
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгч, "Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтад хүний эрх, хууль дээдлэх зарчмыг хангах нь: Байгаль орчны холбогдолтой зөрчлийн хэргийг шалгах аргачлал"-ыг боловсруулсан байна.
- Гадаад харилцааны яамтай хамтран Бизнес ба Хүний эрхийн суурь судалгаа, үнэлгээний тайланг боловсруулснаас гадна бизнес эрхлэгчдэд зориулсан Ковид-19 цар тахлын үед бизнесийн байгууллага өөрийгөө үнэлэх түргэвчилсэн тест боловсруулж, НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмуудын талаарх мэдлэгийн бүтээгдэхүүнүүдээр видео нэвтрүүлэг хийж, нийтийн хүртээл болгосон байна.
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хамтарсан ажлын хэсэгтэй хамтран уул уурхай, дэд бүтцийн төслүүдэд нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх журмын төслийг боловсруулан, БОНБУ-ний тухай журамд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг БОАЖЯ-нд өргөн барьсан нь Засгийн газрын тогтоолоор батлагдан хэрэгжиж эхлээд байна.
- Хүний эрхийн үндэсний комисс (ХЭҮК)-тай хамтран "Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ"-г хийжээ. Үүнд үндэслэн Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх гарын авлага боловсруулж, уул уурхайн компаниудад сургалт, семинар зохион байгуулсан байна.

Тус үнэлгээгээр уул уурхайн салбар дахь байгаль орчны болон хүний эрхийн зөрчлийн асуудлууд үндэсний болон орон нутгийн төрийн байгууллага, бодлого тодорхойлогчдын анхаарлын төвд орж, ХЭҮК-оос гаргадаг Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлд тусгалаа олжээ.

- Дээрх ажлуудын хүрээнд Монголын уул уурхайн үндэсний ассоциаци (МУУҮА), Эрдэс баялаг эмэгтэйчүүдийн холбоо (ЭБЭХ), Хил хязгааргүй алхам ТББ зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж, хариуцлагатай уул уурхайн стандартыг төлөвшүүлэх, хамтын оролцоотой байгаль орчны мониторингийн аргачлалыг нэвтрүүлэх, хүний эрхийн магадлан шинжилгээ хийх арга туршлагыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор танхимын болон цахим сургалтуудыг зохион байгуулжээ.
- БОЗ төслөөс уул уурхайн салбарын оролцогч байгууллагуудтай хамтран ажиллаж, чадавх бэхжүүлэх сургалт, уулзалтыг олноор зохион байгуулсан байна.

- “Эко Трейд Консалтинг” ХХК, “Ногоон титэм” ХХК болон байгаль орчны бусад байгууллагууд, БОНБУ-ний чиглэлээр мэргэшсэн компаниудтай байгаль орчны хамгаалал, нөхөн сэргээлтийн мэдлэгийг дээшлүүлэх, шилдэг арга туршлагыг сурталчлан түгээх зорилгоор хамтран ажиллажээ.
- Геологийн төв лаборатори, Хими, хими технологийн хүрээлэнгийн лабораторитой хамтран геологи, химийн чиглэлээр судалгаа шинжилгээ хийж, шинжлэх ухааны ололт амжилтыг уул уурхайн салбарын хэрэглээнд нэвтрүүлэхэд хувь нэмрээ оруулсан байна.
- Таван аймгийн түвшинд иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж, уул уурхайн салбарын оролцогч талуудыг оролцуулан хамтын оролцоотой байгаль орчны мониторингийг амжилттай хэрэгжүүлсэн байна.

2.2 Өөрчлөлт оруулсан эрх зүйн баримт бичиг

БОЗ төслийн хоёр дахь үе шатанд Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, уул уурхайн салбарт хамааралтай байгаль орчны хууль, тогтоомж, хүний эрх, жендэрийн нөхцөл байдлыг судлах чиглэлд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж, дараах хууль эрх зүйн баримт бичгүүдэд шаардлагатай томоохон нэмэлт өөрчлөлтүүдийн саналыг боловсруулж, заримыг нь батлуулсан байна.

- Хууль дээдлэх зарчмын хэрэгжилтийг үнэлэхдээ Монгол Улсад мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн хэрэгжилтийг сайтар судалж, энэхүү үйл явцаар дамжуулан иж бүрэн судалгааны дүгнэлт гаргаж, нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулан, холбогдох талуудаар хэлэлцүүлж ажиллажээ.
- Уул уурхайн салбарт хамааралтай байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтийг судлахдаа одоо мөрдөгдөж буй хууль, дүрэм журмуудыг иж бүрнээр нь дүгнэн шинжилж, нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай асуудлуудыг тодорхойлжээ. Үүний үндсэн дээр БОНБУ-ний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн бариад байна.
- Уул уурхайн үйл ажиллагааны хүний эрхэд нөлөөлөх байдлыг үнэлснээр хүний эрхийг хамгаалах, сайжруулах чиглэлд өөрчлөлт оруулах шаардлагатай асуудлуудыг тодорхойлсон байна.
- Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч сүйдсэн, нөхөн сэргээгдэлгүй орхигдсон талбайн тооллогыг хийж, холбогдох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулсан байна.
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний журмын хэрэгжилтийн үр нөлөөг хянаж үзсэний үндсэн дээр БОНБУ-ний журамд холбогдох өөрчлөлт оруулах санал боловсруулан, холбогдох талуудаар хэлэлцүүлээд байна.
- Уул уурхайн салбар дахь ажлын байрны чиг үүрэг, ур чадварт жендерт суурилсан дүн шинжилгээ хийж, жендерийн асуудлыг салбарын хууль тогтоомжид тусгуулсан байна.

- Монголын уул уурхайн үндэсний ассоциаци дүрмээ шинэчилж, гишүүн аж ахуйн нэгжүүдийг Хариуцлагатай уул уурхайн кодексыг заавал дагаж мөрдөхийг үүрэг болгосон байна.
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ахалж, холбогдох бүх талын төлөөллийг багтаасан ажлын хэсгээс уул уурхай, аж үйлдвэр, дэд бүтцийн салбарт хэрэгжих төслүүдэд олон улсын чиг хандлагад нийцүүлэн нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх төслийг боловсруулан, холбогдох өөрчлөлтийг БОНБУ-ний журамд тусгасан нь 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн Засгийн газрын 58-р тогтоолоор батлагдан хэрэгжиж эхлээд байна.
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтоос болж эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх эрх зүйн зохицуулалтад томоохон өөрчлөлт оруулсан байна. Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтод эвдэрсэн газрыг нөхөн сэргээх аргачлал болон зааварчилгааг холбогдох талуудтай хамтран боловсруулж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 8 дугаар сарын А/328 тоот тушаалаар албан ёсоор батлуулсан бөгөөд Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яаманд албан ёсоор бүртгүүлэхээр хүргүүлсэн байна.

2.3 Боловсруулсан гарын авлага, аргачлалууд

- 2020 онд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тогтолцооны төвлөрлийг сааруулах, түүнийг хэрэгжүүлэх механизмын бүтээмжийг үнэлж, нэмэгдүүлэх зорилгоор дүн шинжилгээ хийсэн байна. Үүнд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар байгаль орчны үнэлгээний төслийн ангиллыг оновчтой хуваарилах, орон нутгийн байгаль орчны төрийн захиргааны байгууллагуудыг уялдааг хангах, орон нутагт хэрэгжих зарим төсөлд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шийдвэр гаргах, эрх бүхий байгууллагын хийсэн тайланг хэлэлцэн шийдвэрлэх эрхийг олгох байдлаар төвлөрлийг сааруулан ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, үнэлгээний чанарыг дээшлүүлэх, холбогдох байгууллагуудыг чадавхжуулах асуудлууд багтсан байна.
- НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газраас баталсан дэлхийн хамгийн нөлөө бүхий суурь зарчим болох НҮБ-ын “Бизнес ба Хүний эрхийн удирдах зарчмууд”-ыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хариуцлагатай бизнесийн зарчмуудыг сурталчлах, түгээн дэлгэрүүлж хэрэгжүүлэх зорилгоор Бизнес ба Хүний эрхийн үндэсний суурь судалгааг хийжээ. Суурь судалгааны үр дүнгээр төрийн байгууллагууд, бизнес (хувийн болон төрийн өмчит аж ахуйн нэгж), бизнесийн холбоод, иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэн судлаачдыг оролцуулсан өргөн хэлэлцүүлэг хийсэн байна. Суурь үнэлгээг холбогдох талуудаар хэлэлцүүлэх салбарчилсан цуврал хэлэлцүүлгүүд хийсний үндсэн дээр Бизнес ба Хүний эрхийн Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулжээ. Үүнд уул уурхай, хөдөө аж ахуй, жендэр, шүүх, хууль зүй, төр, иргэний нийгэм зэргээр салбар болон сэдвээр тусгайлан хэлэлцүүлсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 231 дүгээр тогтоолоор уг төлөвлөгөө батлагджээ.

- ХЭҮК-той байгуулсан гэрээний дагуу Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагаанд Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийсэн зөвлөмжийн мөрөөр хяналт тавьж, “Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ” хийх гарын авлага (70 хуудас бүхий) боловсруулсан байна. Хяналт шалгалтын явцад холбогдох талууд тус бүс нутагт хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулахын тулд эмнэлгийн баг илгээх, хүнд даацын авто машины зам барих, ариун цэврийн байгууламжийг сайжруулах, ажиллагсдын ээлжийн хуваарь, менежментийг сайжруулах, уурхайн сайт дахь агаарын бохирдлын хяналтыг сайжруулах зэрэг арга хэмжээнүүд авч хэрэгжүүлж байгаа нь тогтоогджээ.
- Уул уурхайн бүс нутагт олон нийтийн оролцоотой байгаль орчны мониторинг хийх аргачлал, гарын авлагыг боловсруулсан байна. Уул уурхайн үйл ажиллагаанд оролцогч талуудын хамтын оролцоотойгоор хяналт тавих нь харилцан ойлголцол, хамтын ажиллагааг сайжруулах чухал механизм болдог. Энэхүү арга нь уул уурхай орон нутаг хоорондын зөрчлийг бууруулж, үр ашигтай хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулж байна. БОЗ төслийн дэмжлэгтэйгээр боловсруулсан ХОБОМ-ын гарын авлагыг олон улсын хэмжээнд ашиглах зорилгоор англи хэл рүү орчуулан гаргажээ. Мөн 2023 онд уг гарын авлагыг шинэчилсэн байна.
- Хариуцлагатай уул уурхайн кодексийн удирдамж, сургалтын модулийг боловсруулжээ.
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтоос болж эвдэрсэн газрыг нөхөн сэргээх аргачлал боловсруулсан байна.
- Дэлхийн 12 оронд хийж нэгтгэсэн “Эмэгтэйчүүд ба уул уурхайн ирээдүй” судалгааны Монгол Улсын тайланг Тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын зөвлөлийн судлаачид боловсруулсан байна. Тус судалгаагаар Монголын уул уурхайн салбар дахь жендэрийн суурь мэдээллийг 10 жилийн үзүүлэлтээр (2010-2020) нэгтгэн боловсруулсан бөгөөд уул уурхайн салбарын хөгжлийн хандлага, нийлүүлэлтийн сүлжээ нь салбар дахь эмэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлж буйг үнэлжээ. Судалгааны хүрээнд уул уурхайн салбарын эмэгтэй ажилтнуудын өмнө тулгарч буй бэрхшээл сорилтуудыг шийдвэрлэх, оролцоо, манлайллыг нэмэгдүүлэхэд дөхөм болохуйц сайн туршлагаудаас сургамж авч, бодлогын өөрчлөлт хийх зөвлөмжийг шийдвэр гаргагчид болон уул уурхайн компаниудад санал болгосон байна.
- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Монгол Улсад мэргэжлийн иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төсөл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Эрдэс баялаг эмэгтэйчүүдийн холбоо” ТББ-тай хамтран “Нэгдмэл чадавхыг бэхжүүлэх: Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалт зохион байгуулсан байна.
- Киргиз, Монгол Улсын уул уурхай, байгаль орчны засаглалын талаар туршлага судлах, харилцан суралцах талбар бий болгох зорилгоор хоёр улсын байгаль орчин, уул уурхайн салбарын мэргэжилтнүүд, иргэний нийгмийн төлөөллүүдийг оролцуулсан семинар, аяллыг хоёр улсад зохион байгуулжээ.

2.4 Чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа

Байгаль орчны засаглал төсөл нь уул уурхайн салбар дахь байгаль орчин, хүний эрхийг хамгаалах хууль эрх зүйн орчин, хэрэгжилтийн тогтолцоог сайжруулан, талуудын олон талт хамтын оролцоог дэмжин, хариуцлагын механизмыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. БОЗ төслөөс хэрэгжүүлсэн чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа нь хувь хүн, байгууллага, хамт олныг байгаль орчныг хамгаалах, үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад нь шаардлагатай мэдлэг, ур чадвар олгоход чиглэсэн байна. Эдгээр үйл ажиллагаа нь байгаль орчны асуудлаар зөв мэдлэг ойлголт төлөвшүүлэх, засаглалын чадавхыг сайжруулах, нөхөн сэргээлтийн аргыг боловсронгуй болгоход чиглэсэн хууль, эрх зүйн зохицуулалттай холбоотой мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, үнэлгээ судалгаа хийх, сургалт семинар, хамтарсан уулзалт зэрэг олон төрлийн үйл ажиллагааг хамарчээ. Чадавх бэхжүүлэх дараах үйл ажиллагаанууд зохион байгуулагджээ. Үүнд:

- “Уул уурхайн үйл ажиллагаан дахь химийн хорт болон аюултай бодис, хог хаягдлын менежмент ба нөхөн сэргээлтийн асуудал” сэдэвт 3 өдрийн сургалт зохион байгуулж, 21 аймаг болон нийслэл хотын мэргэжлийн хяналтын улсын байцаагч нарыг хамруулжээ.
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ), түүний биелэлтийн тайлангийн цахим мэдээллийн сан бий болгох ажлын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагуудаас БОАЖЯ-нд сүүлийн жилүүдэд ирүүлсэн, хянагдсан хэвлэмэл тайлангуудыг сканердан файл үүсгэж, цахим мэдээллийн санд байршуулжээ.
- Гадаад харилцааны яамтай хамтран Бизнес ба Хүний эрхийн гүнзгийрүүлсэн сургалтыг Улаанбаатар хотод зохион байгуулжээ. Сургалтад Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн гишүүд болон хэрэгжүүлэх салбар бүрээс 100 гаруй төлөөлөл хамрагдсан байна. Энэхүү сургалт нь улсын хэмжээнд энэ чиглэлийн мэдлэг, мэдээлэл олгох анхны томоохон хэмжээ гэдгээрээ чухал ач холбогдолтой үйл ажиллагаа болжээ.
- Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний (2018) зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, дүн шинжилгээ хийх олон талт зөвлөлдөх уулзалт зохион байгуулсан байна.
- Орон нутгийн иргэд, төрийн захиргааны байгууллага, уул уурхайн компаниудын төлөөлөлд хамтын оролцоотой байгаль орчны мониторинг (ХОБОМ)-ийн талаар цуврал сургалт зохион байгуулж, хэд хэдэн уурхайд ХОБОМ-ийн жишиг үнэлгээний аргачлалыг туршсан байна. Уул уурхайн үйл ажиллагаанд талуудын оролцоот хамтарсан мониторинг хийх механизмыг институцчилах талаар төрийн болон төрийн бус байгууллагуудтай харилцан туршлага солилцох, суралцах, зөвшилцөх боломж олгох зорилгоор ХОБОМ-ийн үндэсний семинар зохион байгуулсан байна.
- “Хариуцлагатай уул уурхайн жишиг шаардлага”-ыг нэвтрүүлэх ажлын хүрээнд сургалтын модуль боловсруулан, сургагч багш бэлтгэж, 16 компанийг шаардлагыг хэрэгжүүлэх зааварчилгаа болон өөрийн үнэлгээний тайлан боловсруулах сургалтад хамруулжээ.
- Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон газарт нөхөн сэргээлт хийх аргачлалыг боловсруулан батлуулж, Туул голын хамгаалалтын бүсэд туршилтын үзүүлэх сургалт зохион байгуулсан байна.


- Хүний эрхийн нөлөөллийн үнэлгээний сургалт зохион байгуулж, Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын алба, 21 аймаг болон салбарын яам, холбогдох төрийн байгууллага, ТББ-ын 50 гаруй төлөөллийг оролцуулжээ.
- “Хүний эрхэд суурилсан бодлого, төлөвлөлт” сэдэвт сургалт зохион байгуулж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын 40 ажилтан хамрагдсан байна.
- Хүний эрхийн магадлан шинжилгээ (ХЭМШ) сэдвээр Монголын Эрдэс баялаг эмэгтэйчүүдийн холбооноос уул уурхайн компаниудад сургалт явуулж, чадавхжуулж байна.
- Түгээмэл тархацтай /барилгын/ ашигт малтмалыг олборлох явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээх шинэ аргачлалын тухай сургалтыг уул уурхайн компаниуд болон Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төлөөллийг оролцуулан 2023 онд зохион байгуулав.
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны төрийн албан хаагчдад шинээр батлагдсан Бизнес, хүний эрхийн үндэсний хөтөлбөрийн талаар сургалтыг 2023 онд зохион байгуулсан.
- Оюу Толгойн уурхайн төслийн орон нутгийн ханган нийлүүлэгчдэд Бизнес ба хүний эрх, хүний эрхийн магадлан шинжилгээний талаарх сургалтыг 2023 онд Өмнөговь аймгийн Ханбогд сумд зохион байгуулсан байна.
- Орон нутгийн оролцогчид болон иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан ХОБОМ-ийн хээрийн үзүүлэх сургалтыг 2023 онд Баянжаргалан сум болон Багануурт явуулсан байна.

2.5 Ашиг тус хүртэгчдийн талаарх мэдээлэл

ХҮСНЭГТ 1. БОЗ төслийн чадавх бэхжүүлэх сургалтад хамрагдагсдын тоо, 2020-2023 онд

СУРГАЛТ	Нийт оролцогчид
• ХОБОМ-ийн сургалт	161
• Мэргэжлийн хяналтын улсын байцаагчдад зориулсан “Уул уурхайн үйл ажиллагаан дахь химийн хорт болон аюултай бодис, хог хаягдлын менежмент ба нөхөн сэргээлтийн асуудал” сургалт	100
• Бизнес, хүний эрхийн талаарх сургалт (2021)	100
• Нөхөн сэргээлтийн сургалт (2022)	50
• Хүний эрхийн нөлөөллийн үнэлгээний сургалт	50
• Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын ажилтнуудад зориулсан “Хүний эрхэд суурилсан бодлого, төлөвлөлт” сэдэвт сургалт	40
• ХОБОМ хийх аргачлалын сургалт (2022)	40
• ХОБОМ-ийн хорооны гишүүдэд зориулсан сургалт	50
• Компаниудад зориулсан нөхөн сэргээлтийн сургалт (2023)	80
• БОАЖЯ, УУХҮЯ-ны албан хаагчдад зориулсан БХЭ-ийн Үндэсний хөтөлбөрийн талаарх сургалт (2023)	100
• Оюу Толгойн ханган нийлүүлэгчдэд зориулсан БХЭ болон ХЭМШ-ний талаарх сургалт (2023)	35

ГРАФИК 1. БОЗХ-ийн чадавх бэхжүүлэх сургалтад хамрагдагсaдын тоо, хувиар



Мөн “Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтад хүний эрх, хууль дээдлэх зарчмыг хангах нь: Байгаль орчны холбогдолтой зөрчлийн хэргийг шалгах аргачлал” мэргэжлийн хяналтын байцаагчдад зориулсан гарын авлагыг 500 хувь хэвлэн мэргэжлийн хяналтын улсын байцаагчдад хүргүүлжээ.

3. ҮР ДҮНГИЙН МЭДЭЭЛЭЛ (ТООН БОЛОН ЧАНАРЫН)



“Уул уурхайн үйл ажиллагаан дахь химийн хорт болон аюултай бодис, хог хаягдлын менежмент ба нөхөн сэргээлтийн асуудал” сургалт, 2019

БОО төслийн хоёрдугаар үе шатанд хүрсэн гол үр дүн, хөтөлбөрийн ололт амжилтыг тоон болон чанарын үзүүлэлтээр дараах байдлаар тоймлон харуулав.

А. Хууль тогтоомжийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлд:

Тоон үзүүлэлт:

- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 231 дүгээр тогтоолоор “Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлуулсан байна. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16758850092381>
- Хоёр журамд (БОАЖ-ын сайдын 2022 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн А/328 дугаар тушаалаар “Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон газарт нөхөн сэргээлт хийх аргачлал”, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 58 дугаар тогтоолоор БОНБУ-ний журам) тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16758850092381>
- Монголын уул уурхайн үндэсний ассоциациас Хариуцлагатай уул уурхайн кодексийг шинэчлэн баталсан.
- Зарим хууль, журамд нэмэлт өөрчлөлт оруулах ажил хийгдэж байна. (Байгаль орчны нарийвчилсан нөлөөллийн үнэлгээний тухай хуульд тусгах нэмэлт өөрчлөлтийг боловсруулж, БОАЖЯ-нд өргөн мэдүүлсэн).

Чанарын үзүүлэлт:

- Оролцогч талууд хууль тогтоомжид оруулсан өөрчлөлтийн үр нөлөө, ач холбогдлыг онцлон тэмдэглэсэн байна.

Б. Чадавх бэхжүүлэх чиглэлд:

Тоон үзүүлэлт:

- Нийт 11 удаагийн үндэсний хэмжээний сургалт, семинар, чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа явуулсан.
- Сургалт болон чадавх бэхжүүлэх үйл ажиллагаанд нийт 806 оролцогч тал хамрагдсан байна.

Чанарын үзүүлэлт:

- Оролцогчдын мэдлэг, ур чадвар, итгэл үнэмшил нэмэгдсэн. Мөн эерэг санал сэтгэгдэл, олж авсан мэдлэг, ур чадвараа байгаль орчны менежментийн практикт хэрэгжүүлэх ур чадвар сайжирсныг тэмдэглэж байна. (Мэдлэг, ур чадвар сайжирсныг харуулсан кейс судалгаануудыг хавсаргав.)

В. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тогтолцоог сайжруулах чиглэлд:

Тоон үзүүлэлт:

- Аж ахуйн нэгж, байгууллагуудаас цаасаар хүлээн авсан 196 боть буюу 581 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) болон түүний биелэлтийн тайланг сканердаж, БОМТ-ний цахим мэдээллийн санд байршуулсан.
- БОМТ болон тайлан хянан батлагдсан талаарх энэхүү лавлагааны мэдээллийн бааз нь холбогдох мэргэжилтнүүдэд 100% хүртээмжтэй ашиглагдаж байна.
- Мэргэжлийн хяналтын улсын байцаагчдад зориулсан “Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтад хүний эрх, хууль дээдлэх зарчмыг хангах нь: Байгаль орчны холбогдолтой зөрчлийн хэргийг шалгах аргачлал” гарын авлагыг 500 хувь хэвлэн, төв, орон нутгийн байцаагчдад хүргүүлсэн.



Киргиз-Монголын туршлага солилцох хөтөлбөрийн үеэр Мин Кушийн ураны уурхайн нөхөн сэргээлтийн талбайд, Киргиз улс, 2023

Чанарын үзүүлэлт:

- Оролцогч талууд БОНБУ-ний тухай хууль, журмыг шинэчлэх, зөвшөөрөл олгох эрх мэдлийн төвлөрлийг сааруулахын ач холбогдлын талаар илүү их ойлголттой болсон.

Г. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний журамд нийгмийн нөлөөллийн үнэлгээг олон улсын чиг хандлага, жишигт нийцүүлсэн холбогдох өөрчлөлтийг боловсруулах чиглэлд:

Тоон үзүүлэлт:

- Оролцогч талуудын зөвлөлдөх уулзалт, Ажлын хэсгийн гишүүдийн хэлэлцүүлгийг удаа дараа зохион байгуулсны үндсэн дээр нийгмийн нөлөөллийн үнэлгээг олон улсын чиг хандлага, жишигт нийцүүлсэн холбогдох өөрчлөлтийг БОНБУ-ний журамд шинээр оруулж, батлуулсан.

Чанарын үзүүлэлт:

- Шинэчлэгдсэн журам, аргачлалын дагуу нийгмийн нөлөөллийн үнэлгээг дэд бүтцийн том төслүүд дээр хийж эхэлснээр оролцогч талуудын мэдлэг, ойлголт нэмэгдэж, ач холбогдлыг нь үнэлэх хандлага нэмэгдэж байна.

Д. “Хариуцлагатай уул уурхайн жишиг шаардлага”-ыг уул уурхайн компаниудад нэвтрүүлэх чиглэлд:

Тоон үзүүлэлт:

- Хариуцлагатай уул уурхайн кодекст 38 компани нэгдэж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Чанарын үзүүлэлт:

- Уул уурхайн салбар нийгмийн хөрөнгө оруулалт, байгаль орчны хамгаалал, орон нутгийн хөгжил, хүний нөөцийн чиглэлээр хичээн ажиллаж байгаа нь зарим компаниудын хариуцлагатай үйл ажиллагаа, олон нийтийн оролцоог дэмжсэн, байгаль орчинд ээлтэй санаачилгуудаас нь харагдаж байна.

Е. Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний чиглэлд:

Тоон үзүүлэлт:

- Тавантолгойн бүлэг ордод үйл ажиллагаа явуулдаг компаниуд хамрагдсан.
- Чанарын үзүүлэлт:
- Хүний эрхийг хамгаалах байдал сайжирч, нөлөөлөлд өртсөн талуудад эерэг үр нөлөө гарч байна.

Ё. Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон газрын нөхөн сэргээлтийн чиглэлд:

Тоон үзүүлэлт:

- “Очирням” ХХК-ийн элс, хайрга олборлосон талбайд жишиг нөхөн сэргээлтийн ажил хийсэн.
- Тухайн сонгосон газрыг 100% нөхөн сэргээсэн.

Чанарын үзүүлэлт:

- Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтын үед урт хугацааны экологийн тогтвортой байдлыг хангахад хувь нэмэр оруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр экологийн сайжруулалт, тогтвортой газар ашиглалтад тавигдах шаардлагуудын талаарх ойлголт сайжирсан.



Киргиз-Монголын туршлага солилцох хөтөлбөр, ХОБОМ-ийн талбай, Төв аймгийн Баянжаргалан сум, 2023

4. КЕЙС СУДАЛГАА



Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагаанд Хүний Эрхэд Нөлөөлөх Байдлын Үнэлгээ хийх үеэр авсан нүүрс тээврийн нөхцөл байдлын дүр зураг, 2021

4.1 Кейс судалгаа 1:

Мэдлэг түгээх алхам – Жендерээс хүний эрхийн чиглэлд

Эрдэс баялгийн салбарт Хүний Эрхийн Магадлан Шинжилгээ хийх аргазүйг нэвтрүүлсэн нь

Бизнесүүдэд Хүний эрхийн магадлан шинжилгээ (ХЭМШ) хийлгэх нь олон улс оронд хууль тогтоомжийн шаардлага болон хувирч байна. Монгол Улсын хувьд ч гэсэн Засгийн газраас “Бизнес ба Хүний эрхийн үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө” (2023.06.14)-г баталснаар ХЭМШ хийлгэх үйл явц албажсан гэж хэлж болно. ХЭМШ нь манай улсын хувьд шинэ тутам ойлголт хэдий ч НҮБХХ-ийн Байгаль орчны засаглал, Бизнес ба хүний эрх төслийн хүрээнд уул уурхай, хүнс, ноос ноолуурын салбарын 3 холбоог чадавхжуулсны үндсэн дээр тэднээр дамжуулан тухайн салбаруудад ХЭМШ нэвтрүүлэх туршилтын төслийг хэрэгжүүлснээр энэ чиглэлийн мэдлэг ойлголт амжилттайгаар түгэн дэлгэрч байна.

“Эрдэс баялаг эмэгтэйчүүдийн холбоо” (ЭБЭХ) ТББ нь харьцангуй залуу олон нийтийн байгууллага юм. 2018 онд анх удаа салбарын эмэгтэйчүүдийн санаачилгаар “Эрдэс баялаг эмэгтэйчүүд” чуулган зохиогдож, дараа жилийн чуулганаас холбоо байгуулах санаачилга гарснаар 2020 онд ЭБЭХ мэндэлжээ. Нэр болон анхны зорилгоос үүдэн ЭБЭХ-г эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх байгууллага гэж ойлгох нь бий. Тус холбоо эрдэс баялгийн салбарт жендэрийн ойлголтыг нэмэгдүүлж, хэвшмэл хандлагыг өөрчлөх чиглэлд цөөн жилд цөөдөхөөргүй намтар, туршлага бий болгоод байгаа юм. Харин 2022 онд НҮБХХ-ийн ХЭМШ хөтөлбөрийн хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” ХК-д ХЭМШ хийсэн нь жендерээс хүний эрхийн чиглэлд хийсэн том алхам байв. Улмаар үйл ажиллагаагаа тэлэх шинэ түүхийн эхлэх цэг болжээ.

Энэхүү хөтөлбөрт ЭБЭХ-г сонгосон нь уул уурхайн салбарт жендэрийн цахим сургалтын бүтээгдэхүүн боловсруулж, Хариуцлагатай уул уурхайн жишиг шаардлага бичилцсэн мэдлэг, туршлагыг харгалзсаных байв.

ЭБЭХ-ны зөвлөх Ш.Байгалмаа:

ХЭМШ-гээр чадавхжихад тухайн салбарын бизнесийг мэдэхгүй бол цаг хугацаа их зарцуулна. Тиймээс туршлагатай багийг чадавхжуулбал цаг хугацаа төдийгүй хүний нөөцийг хэмнэх ач холбогдолтой юм. Энэ утгаараа ЭБЭХ-г хөтөлбөрт сонгосны хэрэг гарч, маш богино хугацаанд үр дүн гаргасан.

Чадавхжуулах сургалтад хамрагдсаны дараа ЭБЭХ Монголын хамгийн том төрийн өмчит нүүрсний компанид ХЭМШ хийсэн нь асар том хичээл болсон юм. Энэ нь Монголын эрдэс баялгийн салбарт анхны туршлага боловч богино хугацаанд үр дүнтэй хэрэгжжээ. Үүнд компанийн хүчин чармайлт, удирдлагын манлайллаас гадна ХЭМШ хийсэн багийн туршлага, ажлын арга барил голлох үүрэгтэй байв.



Зураг 2. ЭБЭХ нь Эрдэнэс Тавантолгой компанитай ХЭМШ хийх санамж бичигт гарын үсэг зурж байгаа нь, 2022 он

ЭБЭХ-ны тэргүүн О.Туяа:

ХЭМШ нь бүхий л оролцогчдын хувьд цоо шинэ мэдлэг байсан. “Эрдэнэс Тавантолгой”-д ХЭМШ хийхдээ бид бүгдээрээ суралцсан. Компанийн хамт олонтой хамтдаа суралцангаа, үл буруутгах зарчмаар ажилласан. Суурь судалгаа хийхэд бидний сургалтаар олж авсан мэдлэг маань маш их цэгцэрч байлаа.

ЭБЭХ-ны зөвлөх Ш.Байгалмаа:

Төслийг хэрэгжүүлэх явцад жижиг өөрчлөлтүүд тэр даруйдаа гарч байсан нь биднийг их урамшуулсан. Ажлын байрны үзлэгийн дараа “Эрдэнэс Тавантолгой” компанийнхан оффистоо хүүхдийн өрөө гарган тохижуулж, компанийн удирдлагууд хамт олныхоо оролцоог үнэлдэг болж, Баасан гариг бүрийг ажиллагсадаа сонсдог өдөр болгож, цагийн уян хатан зохицуулалт гаргаж, ажиллагсад болон удирдлагууд мэдлэгжсэн. Газар дээрээ өөрчлөгдөн, байгууллагын соёл, хүмүүсийн хандлага, зан үйлийн төлөвшил сайжирч, хүний эрхэд хүндэтгэлтэй хандаж эхлэхийг харах үнэхээр сайхан байсан.



Зураг 3. ХЭМШ-ний зөвлөмжийн дагуу Эрдэнэс Тавантолгойн төв оффис дээр байгуулагдсан хүүхдийн өрөө, 2022 он

Энэхүү төслийн үр дүнд уул уурхайн салбарт ХЭМШ хийх мэдлэг, чадамж, аргазүйн эхний туршлага бий болоод байна. Мэдлэгийн бүтээгдэхүүнүүд үүсээд зогсохгүй ХЭМШ хийх чадавхтай баг бий болсон нь төслийн хамгийн гол үр дүн юм. Ирээдүйд хэрэгцээ шаардлага нь улам өсөх ийм ур чадвар бий болж буй нь эрдэс баялгийн салбарт ч таатай мэдээ. ХЭМШ-ний онцлох давуу тал нь компани нэг удаа иж бүрэн ХЭМШ хийлгээд мэдлэг авчихвал дараа нь өөрсдөө үргэлжлүүлээд хийх чадавхтай болж үлддэг явдал.



Зураг 4. Уул уурхайн компанид ХЭМШ хийж буй үйл ажиллагаа, 2022 он

Харин ЭБЭХ-ны хувьд энэ мэдлэг, туршлагаа зөвхөн нэг төслийн түүх болгож үлдээсэнгүй. Өдгөө ЭБЭХ-ны үйл ажиллагааны голлох нэг чиглэл нь ХЭМШ болоод байна. Тэд уул уурхайгаар хязгаарлалгүйгээр бизнесийн бүхий л салбарт хүний эрхийг хүндэтгэгч компани байх нь ирээдүйн үнэ цэнийн өсөлтөд хэрхэн эергээр нөлөөлөхийг уйгагүй сурталчлан таниулж байна. Хийсэн сургалт танилцуулгууд нь бизнесийн байгууллагуудыг том жижиг гэхгүйгээр хүний эрхийг хүндэтгэх үүрэг, хариуцлагын талаар мэдлэг ойлголттой болгож, сэдэлжүүлж байна. Энэ төслийн дараа ЭБЭХ-ны зөвлөхүүд 2023 оны байдлаар 202 байгууллагын 310 хүнд Хариуцлагатай бизнес ба хүний эрхийн мэдлэгийг түгээжээ. Мэдлэг түгээж буй байгууллага, хүмүүсийн тоо өдөр өдрөөр өссөөр байна. Эдгээрээс НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр 20 байгууллагын 24 хүнийг хамруулсан ДЭМ хөтөлбөрийг эс тооцвол бусдад нь мэдлэг, туршлагаа үнэ төлбөргүй хуваалцжээ.

ЭБЭХ-ны тэргүүн О.Туяа:

Манай ТББ-ыг чадавхжуулснаар бид шинэлэг зүйлд суралцсан. Бидэнд өөрсдөд эерэг сайжруулалтын зан үйл сууж, бүхнийг хүний эрхийн “линз”-ээр харах болсон. Нэг ёсондоо хүний эрх төвтэйгээр асуудалд хандах чадамжтай болж байна. Одоо тэр мэдлэгээ бусдадаа шилжүүлж байна.

ДЭМ буюу зохистой хөдөлмөр эрхлэлтийн мэдлэг түгээх хөтөлбөрийн зорилго нь 20 жижиг бизнест хөдөлмөр эрхлэлтийн мэдлэг ойлголт өгч, зан үйлийн өөрчлөлт хийх байв. Үүний тулд ЭБЭХ ажлын байрны нөхцөлийг өөрчлөх замаар ажилтан, ажил олгогчийн хамтын ажиллагааг сайжруулахыг зорьжээ. “Ажлаа хийхэд тань үүнийг ингэчихээсэй гэх ямар бодол орж ирдэг вэ? Тэр чинь л ажил сайжруулах санаачилга” гэж чиглүүлж өгснөөр ажилтнуудаас төсөөлөөгүй бүтээлч саналууд гарч эхэлж. Өөдсөө ангилах, ажлын байрны үзлэг хийж, аюулаа таньж, тэмдэг тэмдэглээ хийхээс эхлээд 20 бизнес дундаа нэг түгээлтийн машинтай болтлоо өөрчлөлтүүд гарав. Ердөө хогийн савны байршил өөрчлөхөд л эмх цэгц бий болж, хөдөлмөрийн бүтээмжид нөлөөлж, хамтын ажиллагаа сайжирч, уур бухимдал багасаад ирсэн нь бүгдийг гайхшруулжээ.

Ажлын арга барил, үйлдлээ сайжруулах жижигхэн ийм өөрчлөлтүүд хүн бүхэнд мэдээжийн зүйл мэт боловч хэн ч хэлдэггүй учраас мэдэхгүй, санаанд ордоггүй байж. Харин хэлж чиглүүлж өгсний үрээр ДЭМ-ийн 20 бизнесийн бүгдийнх нь ажлын байрны нөхцөл сайжирчээ. Гол нь ажлын байрны эмх цэгцээс эхэлсэн энэ өөрчлөлт ажил олгогч ажилтан хоёрыг бие биенээ хамтран зүтгэгчид гэсэн ойлголцолд хүргэж чадсан байна. Хөгжлийн үндэс бол хүн бүхний оролцоо гэдгийг ойлгосноор ДЭМ-ийнхэн өөрсдөө ч сэтгэлгээний хувьд ихээхэн өөрчлөгджээ. Эрүүл аюулгүй ажлын байрыг зөвхөн ажил олгогч бус ажилтнууд бүгдээр хамтарч бий болгогчийг ойлгож авснаа төслийн хамгийн чухал үр дүн гэж ДЭМ-ийнхэн үнэлсэн юм. Өөр ямар ч төсөл хөтөлбөрөөс ийм энгийн мөртлөө чухал мэдлэг авч байгаагүй гэж тэд сэтгэл дүүрэн ярьж байна.

Энэ бол НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс ЭБЭХ тэргүүтэй 3 холбоонд, тэдний нэг ЭБЭХ-ноос жижиг дундуудад мэдлэг шилжүүлж, чадавхжуулсан чухал хөрөнгө оруулалт юм.

4.2 Кейс судалгаа 2:

Уул уурхайд хариуцлага төлөвшүүлэх эхлэл

Хариуцлагатай уул уурхайн жишиг шаардлага ба үнэлгээний аргачлалыг уул уурхайн компаниудад нэвтрүүлсэн нь

Хариуцлагатай уул уурхайн санал санаачилга Монгол Улсад 2006 оноос анх яригдаж эхэлсэн ч бодит ажил хэрэг болгох эхлэлийг НҮБХХ-ийн Байгаль орчны засаглал төслөөс тавьжээ. Тус төслөөс 2017 онд анх Хариуцлагатай уул уурхайн жишиг шаардлагыг гаргасан бөгөөд 2020 онд түүнд суурилсан “Хариуцлагатай уул уурхайн хөтөлбөр”, “Хариуцлагатай уул уурхайн кодекс”-ийг Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци (МУУҮА)-тай хамтран боловсруулсан байна. Улмаар эхний 16 компанид сургалт явуулж, нэвтрүүлж эхэлснийг өдгөө МУУҮА салбарын хэмжээнд амжилттай үргэлжлүүлж, түгээн хөгжүүлж байна.

2006 онд Монгол Улс Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-д нэгдэхийн өмнөхөн МУУҮА-иас хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх санаачилгыг анх дэвшүүлж байв. Энэхүү санаачилгын үндсэн дээр төрийн болон иргэний нийгмийн байгууллага, компаниудын төлөөлөл хамтран уул уурхайн компаниудын үйл ажиллагаандаа дагаж мөрдөх Хариуцлагатай уул уурхайн 8 зарчмыг тодорхойлж, хэрэгжүүлэх Тунхаг бичигт 80 гаруй байгууллага, иргэдийн төлөөлөл гарын үсгээ зурж байжээ. Мөн “Хариуцлагатай уул уурхайн санаачлага” ТББ-ыг байгуулж, хэрэгжүүлэгч байгууллагаар тодорхойлсон байна. Хариуцлагатай уул уурхайн зарчмын талаар Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УИХ, Засгийн газрын холбогдох баримт бичгүүдэд тусгалаа олж, ахиц дэвшил гарч байсан ч хангалттай биш, хэрэгжилт удаашралтай байлаа.



Зураг 5. Багануурын уурхайн Хариуцлагатай Уул Уурхайн Кодексийн сургалт, 2021 он

Хариуцлагатай уул уурхайн шалгуур бий болгох төслийг санаачлагчдын нэг, МУУҮА-ийн Гүйцэтгэх захирал асан Н.Алгаа:

“Хариуцлагатай уул уурхайн зарчмыг хэрэгжүүлэхээр “Хариуцлагатай уул уурхайн санаачлага” ТББ багагүй хүчин чармайлт гаргасан. Гэхдээ ямар арга замаар хэрхэн хэрэгжүүлэх тухайд яах аргагүй мэдлэг, туршлага дутаж байлаа. Зорилгын хувьд компанийн сайн засаглал болон нийгмийн хариуцлагын зарчмуудтай ижил төстэй ч алийг нь ч хэрэгжүүлсэн туршлага Монголд байсангүй. ТББ-аас хариуцлагатай уул уурхайг дүгнэх шалгуур үзүүлэлт боловсруулж, оролцогч талуудад танилцуулахад хүлээж аваагүй. Шалтгаан нь хэн, хэзээ, хэрхэн дүгнэх нь тодорхойгүйгээс гадна дүгнэх шалгуур үзүүлэлтийн хувьд хүлээн зөвшөөрөгдсөн заавар, аргачлал санал болгож чадаагүйтэй холбоотой байв” хэмээн дурсжээ.

НҮБХХ-өөс 2017 онд Монголын уул уурхайн салбарт хийсэн судалгаагаар авлигын эрсдэл өндөр байгаа нь хууль эрх зүйн орчны зохицуулалт дутуутай холбоотой гэсэн дүгнэлт гарсан байна. Уг судалгаанд үндэслэн НҮБХХ-өөс МУУҮА-тай хамтран компаниудын хариуцлагыг үнэлэх, сайжруулах аргачлал боловсруулсан байна. Ингэхдээ уул уурхайн нөлөөллийг бүхэлд нь хамарсан, олборлох салбарын хариуцлагыг бүрэн дүүрэн илтгэж чадахуйц шаардлага, шалгуур үзүүлэлтүүд гаргахыг зорьжээ. Судалгааны хүрээнд олон улсын 24 санаачилгыг судалж, тэдгээрээс давхардсан тоогоор 600 гаруй шаардлагыг авч үзсний үндсэн дээр хариуцлагатай уул уурхайн кодексийн шаардлагуудыг тодорхойлсон байна. Улмаар Монголын компаниудын хөгжил төлөвшилд тохируулан 29 шалгуураар “Хариуцлагатай уул уурхайн сайн дурын кодекс”-ийг боловсруулжээ. Уг аргачлалаар анхлан Багануурын уурхайг үнэлж, туршсан байна. Туршилт амжилттай болсон тул уул уурхайн тэргүүлэх 16 компанийг уг санаачилгад нэгтгэн, кодекс нэвтрүүлэх чиглэлээр сургаж дадлагажуулжээ. Төслийн үр дүнд кодексийг цаашид салбарын мэргэжлийн байгууллага нь хөгжүүлээд явах боломжтой гэж үзсэн байна.

2019 онд УУХҮЯ болон МУУҮА-иас “Хариуцлагаар нэгдье” аян зохиож, уг аяны хүрээнд тэргүүлэх 8 компани нэгдэж харилцан ойлголцлын Санамж бичигт гарын үсэг зурснаар “Хариуцлагатай уул уурхайн хөтөлбөр” хэрэгжиж эхэлсэн юм. Өнөөдрийн байдлаар “Хариуцлагатай уул уурхайн сайн дурын кодекс”-ыг 38 компани үйл ажиллагаандаа нэвтрүүлж, эгнээ нь тэлсээр байна.

МУУҮА-ийн Гүйцэтгэх захирал Г.Эрдэнэтуяа:

Хариуцлагатай уул уурхайн кодекс (ХУУК)-ийг уул уурхайн компаниуд сайн дурын үндсэн дээр хүлээн зөвшөөрч хэрэгжүүлж байсан бол 2022 оноос МУУҮА дүрмээ шинэчилснээр гишүүн байгууллагууд кодексийг шууд хэрэгжүүлэх үүрэг хүлээх болсон. Кодексийн шаардлагыг хангасан компаниуд Тогтвортой хөгжлийн 17 зорилтын 7-8-ыг хангаж чадна. Энэ бол маш чухал үзүүлэлт. Эрдэс баялгийн салбар маш олон оролцогч талтай. Тэр бүгдэд өөр өөрийн хүсэл сонирхол бий. Харин тэдгээр оролцогчид буюу компани, төрийн байгууллага, иргэний нийгэм, орон нутгийн хүсэл сонирхол огтлолцох цэг нь ХУУК юм.

Өнгөрсөн таван жилд МУУҮА нь Байгаль орчны засаглал төслөөс суурийг нь тавьсан кодексийг улам боловсронгуй болгож, “Хариуцлагатай уул уурхайн хөтөлбөр” цогц баримт бичгийг боловсруулаад байна. Уг хөтөлбөрийн хүрээнд хараат бус хөндлөнгийн үнэлгээний 23 аудиторыг бэлтгэж, эдгээр мэргэжилтнүүд компаниудад хөндлөнгийн үнэлгээ хийж эхлээд байна.



Зураг 6. Монголын уул уурхайн үндэсний ассоциаци 2022 оны Уул Уурхайн долоо хоногоор Хариуцлагатай уул уурхайн кодекст нэгдэх компаниудтай санамж бичигт гарын үсэг зурсан нь

Компаниудын өөрийн үнэлгээ

Оюутолгой	Энержи Ресурс	Платинум Ланд	Саусгоби Сэндс	Хангад Эксплорэйшн
100%	91.6%	91.6%	83%	89.2%

Монгол Улсад хариуцлагатай уул уурхайн компанийг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг ийнхүү тодорхой кодексоор үнэлэх болсон нь эрдэс баялгийн салбарын хөгжилд чухал дэвшил юм. МУУҮА кодекст нэгдэх компаниудын хүрээг улам тэлж, жижиг дунд компаниудад нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна. “Хариуцлагатай уул уурхай” хөтөлбөрийг дэмжсэн эерэг хандлага бий болж буйн нэг илрэл нь салбар хоорондын түншлэл сайжирч, иргэний нийгмийн байгууллагуудын идэвх оролцоо нэмэгдэж байгаа явдал. Хөтөлбөрийг дэмжсэн хамтын ажиллагааны санамж бичгийг “Монгол нүүрс” ассоциацитай (2023.08.03), БОАЖЯ-тай (2023.08.14), эрчим хүчний салбарын “Ньюком” групптэй (2023.08.18) тус тус байгуулаад байна.

Кодексийг ийнхүү өргөн хүрээнд түгээн дэлгэрүүлэхийн хэрээр Монголын эрдэс баялгийн салбарт хариуцлагатай үйл ажиллагаа төлөвшин тогтох ач тустай. Энэ нь эрдэс баялгийн салбарын оролцогч бүхий л талд үр өгөөжөө өгөхөөс гадна Монгол Улсын тогтвортой хөгжилд чухал хувь нэмэртэй юм.

4.3 Кейс судалгаа 3:

Нөхөн сэргээлтийн аргачлалыг талуудын оролцоотой боловсруулан батлуулав

Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон газарт нөхөн сэргээлт хийх аргачлал боловсруулж, нэвтрүүлсэн нь

Уур амьсгалын өөрчлөлт болон бизнесийн үйл ажиллагаанаас үүдэлтэй газрын доройтол, эвдрэл Монгол орны хувьд нэн тулгамдсан асуудлын нэг болоод байна. Тэр дунд түгээмэл тархацтай ашигт малтмал (ТТАМ) олборлогчид буюу манайхны хэлж заншсанаар зам, барилгад ашиглах зорилго бүхий элс, шавар, хайрга, дайрга олборлогч компаниудын нөхөн сэргээлгүй орхисон талбайнууд багагүй хувийг эзэлдэг. Үүний нэг жишээ бол Дарханы авто замын дагуу ухаж сэндийлээд орхисон уул толгод, ундуй сундуй чулуу шорооны овоолгууд юм. Эгээ л дайны ул мөр гэлтэй харагдах ийм элс хайрганы карьер, ухсан нүх Монгол орны бараг бүх сум суурин газарт бий.

ТТАМ олборлогч аж ахуйн нэгжүүдэд нөөцийг ашиглаж дууссан талбайд нөхөн сэргээлт хийхийг үүрэгжүүлсэн Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн заалт бий. Гэвч хуулийн хэрэгжилт туйлын хангалтгүй, нөхөн сэргээлт хийдэг аж ахуйн нэгж цөөн, хийсэн нь төдийлөн шаардлага хангахуйц биш байна. Шалтгаан нь томоохон уул уурхайн компаниудад зориулан боловсруулсан нөхөн сэргээлтийн аргачлал нь ТТАМ ашигладаг жижиг хэмжээний аж ахуйн нэгжүүдэд хэт нүсэрддэг төдийгүй ихээхэн зардал мөнгө шаарддагтай холбоотой юм. Мөн нөхөн сэргээлтийг хэрхэн хийх талаар заавар чиглүүлэг дутмаг явдал ч нөлөөлдөг аж.

Үүнд гарын авлага болох аргачлал болон зааварчилгааг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Байгаль орчны засаглал төслийн хүрээнд БОАЖЯ-ны захиалгаар боловсруулж батлуулжээ. Батлуулаад зогсолгүй загвар нөхөн сэргээлтийг хийж, холбогдох талуудыг



Зураг 7. Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон газарт нөхөн сэргээлт хийх үзүүлэх сургалт, 2022

сурган, амьдралд хэрэгжүүлээд эхэлжээ. Уг аргачлал нь БОАЖ-ын сайдын 2022 оны А/328 тоот тушаалаар батлагдан хэрэгжиж байна. Аргачлалыг боловсруулах явцад холбогдох төрийн байгууллагууд болон олборлогч компаниуд зэрэг талуудын төлөөллийг өргөнөөр оролцуулан, олон удаагийн хэлэлцүүлэг хийж зөвшилцөн батлуулсан нь цаашид нөхөн сэргээлтийг бодитоор амьдралд хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой болжээ.

ТТАМ-ын нөхөн сэргээлтийн аргачлалыг Монголын нөхцөлд тохируулан боловсруулж, уг аргачлалын дагуу “Очирням” ХХК-ийн талбайд нөхөн сэргээлтийн үзүүлэх сургалт зохион байгуулсан “Ногоон титэм” ХХК-ийн судлаач уг аргачлалын онцлог болон давуу талын талаар ийнхүү ярих:

“Ногоон титэм” ХХК-ийн судлаач Б.Алтангэрэл

ТТАМ-ын талбайн хэмжээ харилцан адилгүй байдаг. Зарим аж ахуйн нэгжүүд хэдэн зуун га газартай бол зарим нь маш бага буюу хэдхэн арван га газарт үйл ажиллагаа явуулдаг. Энэ нь тухайн компани ТТАМ-ыг ямар зорилгоор, мөн хэр хэмжээний нөөцийг, хэр хугацаанд ашиглахтай холбоотой. Гэхдээ ихэнх компаниудын хувьд жижиг буюу хэдхэн арван га талбайтай байдаг. Тэр хэмжээгээр нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ багасдаг. Тиймээс жижиг талбайд хэрхэн нөхөн сэргээлт хийж болохыг энэ аргачлалаас мэдэж болно. Үүний жишээ нь “Очирням” компанийн талбай. Бид жишиг нөхөн сэргээлт хийхдээ 1 га газарт олон наст ургамлын үр цацаж, бог малаар гишгүүлж үрсэлгээ хийлгэхийн тулд өвс тараасан. Бог малаар гишгүүлэх нь үр суулгах байгалийн хялбар арга. Үрсэлгээ хийхийн тулд сургалтын талбайд 20 хонь, 10 боодол өвс, 1000 литр ус урьдчилан бэлтгэсэн. Үүнд тодорхой хэмжээний зардал гарч байгаа ч энэ нь томоохон машин техник ашиглахаас маш хямд тусна. Мөн нөхөн сэргээлт хийхдээ байгаль орчинд ээлтэй буюу элдэв машин техник, түлш шатахуун ашиглаагүй нь гол давуу тал юм. Улаанбаатарын ойролцоо ТТАМ олборлодог компаниуд гол төлөв хотын зах, хотын ойролцоох захын дүүрэгт байдаг тул ийм аргаар нөхөн сэргээлт хийх боломжтой.

“Элс, хайрга, дайрга үйлдвэрлэгч компаниудын холбоо” ТТБ-ын Гүйцэтгэх захирал Ц.Батсайхан:

Бидэнд өмнөх аргачлал нь хэтэрхий том нүсэрдээд байсан. ТТАМ олборлогчдод гарын авлага болчихоор тодорхой бөгөөд хялбархан аргачлалтай болсноор бид түүнийг бариад компаниудаа шахаад явахад амар болж байна. Мөн аргачлал боловсруулах явцдаа компаниудыг оролцуулан саналыг нь авч хамтран боловсруулсан нь хэрэгжилтэд маш дөхөмтэй боллоо” хэмээн аргачлалын амьдралд нийцтэй байдлыг үнэлж байна.



Зураг 8. Түгээмэл тархацтай ашигт малтмалын уурхайн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх сургалт, 2021 он

Сургалтын дараа оролцогч аж ахуйн нэгжүүдээс түгээмэл тархацтай ашигт малтмалын нөхөн сэргээлтийг үр дүнтэй байлгах чиглэлд гаргасан саналын дийлэнхэд сургалт чухал гэж үзжээ. Үүнд дүйцүүлэх нөхөн сэргээлтийг үйл ажиллагаа явуулж буй талбайдаа хийдэг болох, байгаль орчны нөхөн сэргээлтийн практик дадлагыг тогтмол хийх, холбогдох сургалтуудыг төрөл бүрийн хэлбэрээр зохион байгуулах, аж ахуйн нэгжүүд мэдлэг туршлагаа солилцох нь чухал гэж үзсэн байна. Энэ бүхэн ийм чиглэлийн үзүүлэх сургалт, хэлэлцүүлэг ихээхэн дутагдалтай, хэрэгцээ шаардлага өндөр байгаагийн илрэл юм.

Монгол Улсын хувьд дэд бүтэц, барилга байгууламж барих хэрэгцээ шаардлага өдрөөс өдөрт нэмэгдсээр байгаа. Үүнийг дагаад ТТАМ-ын хэрэгцээ улам өснө. Тиймээс ТТАМ олборлогч аж ахуйн нэгжүүдийг нөхөн сэргээлт хийх талаар чадавхжуулах, хэрэгцээт сургалтыг зохион байгуулах, сургалтаар дамжуулан аж ахуйн нэгжүүдийн харилцаа холбоог сайжруулж, туршлага солилцох үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах хэрэгцээ шаардлага цаашид ч байсаар байна. Үүнд түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон газарт хийх нөхөн сэргээлтийн аргачлал болон түүний дагуу зохион байгуулсан нөхөн сэргээлтийн үзүүлэх сургалт жишиг болох чухал ач холбогдолтой юм.

4.4 Кейс судалгаа 4:

ХОБОМ - Итгэлцэл дутсан орон зайд иргэдийн оролцоог бодитоор хангасан хөтөлбөр

Хамтын оролцоотой байгаль орчны мониторингийн механизмыг түгээн дэлгэрүүлэх нь

Н.Баярсайхан нь уул уурхайн салбарт идэвхтэй ажилладаг иргэний нийгмийн байгууллагын нэг “Хил хязгааргүй алхам” ТББ-ын тэргүүн. Тэрбээр 10 гаруй жилийн өмнөөс уул уурхайн нөлөөллийн бүсийн иргэдтэй хамтран ажиллаж, уул уурхайн компаниудыг хууль ёсны дагуу ажиллахыг шахаж, шаардаж ирсэн иргэний нийгмийн төлөөлөл юм. 2011 онд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хуулийн хэрэгжилтийг хянах иргэдийн үнэлгээний картны загвар, гарын авлага гаргаж байсан тэрбээр уул уурхайн компаниудын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, иргэдийн хяналтыг нэвтрүүлэх чиглэлд бодитой алхмуудыг хийсээр иржээ. 10 гаруй жилийн энэхүү туршлагадаа үндэслэн, НҮБХХ-ийн Байгаль орчны засаглал төслөөс зарласан ХОБОМ-ийн аргачлал боловсруулах, хэрэгжүүлэх нээлттэй сонгон шалгаруулалтад оролцож, улмаар шалгаран, 2020 оноос ХОБОМ-ийн төслийг хэрэгжүүлсэн байна.

“Хил хязгааргүй алхам” ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан:

“Бүх талхүлээн зөвшөөрөхүйц хялбар аргачлал гаргах шаардлагатай байсан. Талуудад мэдлэг олгох, салбарыг ойлгуулах, улмаар хамтран ажиллах, ойлголцох, иргэдийг оролцуулах ажлын эхлэлийг тавья гэсэн анхны зорилго маань давж биелсэнд баяртай байдаг. Одоо бол талууд аль аль нь хожих ёстой гэдэг үндсэн концепц бүрэн хангагдаж, орон нутаг хөгжлөө тодорхойлох, байгаль орчноо сүйтгэхгүйгээр авч үлдэх, иргэд нь эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ хангахад өөрсдөө оролцох, компани нь засаг захиргааны байгууллагыг ашиглан, иргэдийн эсэргүүцлийг дарах, намжаах гэдгээ больж иргэдтэйгээ хамтран ажиллаж, хамтдаа хариуцлага хүлээдэг болох хандлага руу явж байна” хэмээн ХОБОМ-ийн төслийн үр дүнг дүгнэж байна.



Зураг 9. Талбайд ХОБОМ хийж байгаа нь, Айраг сум, 2021 он



Зураг 10. ХОБОМ-ийн хороо байгуулах хурал, Баянжаргалан сум, 2020 он

Одоогийн байдлаар Завхан аймгийн Дөрвөлжин сумын “Баян-Айраг Эксплорэйшн”, Төв аймгийн Баянжаргалан сумын “Цэцэнс Майнинг & Энержи”, Дорнод аймгийн Баяндун сумын “Эс Жи Майнинг”, Дорноговь аймгийн Даланжаргалан сумын “Говийн шандаст хүлэг”, “Эко хэлхээ”, Айраг сумын “Янтай Уул”, “Мэн Ли Да”, Хөвсгөл сумын “Сора говь” компаниуд болон “Багануур” ХК дээр ХОБОМ-ийн төслүүд хэрэгжиж байна. Бүгдэд нь эерэг өөрчлөлт гарч байгаад ХОБОМ хэрэгжүүлэгч багууд болон Н.Баярсайхан сэтгэл өөдрөг явна.

ХОБОМ амжилттай хэрэгжих суурь нь уул уурхай ба байгаль орчны талаар иргэд болон нутгийн захиргааны ажилтнуудыг мэдлэг мэдээлэлтэй болгох гэдгийг Н.Баярсайхан онцолсон юм. Гэхдээ энэ бүхэн анхандаа тийм ч амар байсангүй. Компаниуд ойлгохгүй, дэмжихгүй байх, компани, иргэдийг хооронд нь зуучилж, ойлголцуулахаас эхлээд багагүй бэрхшээлийг туулжээ. Эцэст нь эерэг үр дүнд хүрдгийн тодорхой нэг жишээ бол Төв аймгийн Баянжаргалан сумд хэрэгжсэн ХОБОМ-ийн төсөл юм.

Баянжаргалан сумд “Цэцэнс Майнинг & Энержи” компани дээр анх ХОБОМ хэрэгжүүлэхээр талуудтай уулзах үеэр малчид уйлж, худлаа ярилаа хэмээн компанийн төлөөлөл рүү сав суулга хүртэл шидсэн явдал гарчээ. Малчин Х тэр л дургүйцэж бухимдсан олны нэг байв. “Цэцэнс Майнинг & Энержи” компанийн үйл ажиллагаанаас болж худгийн ус татарч байна гэж ихэд бухимддаг байж. ХОБОМ-ийн үндсэн зорилго бол үйл ажиллагаандаа тухайн бүсийн малчдыг оролцуулах тул малчин Х-д ХОБОМ-ийн ач холбогдлыг ойлгуулж, татан оролцуулснаар тэрээр өөрийнхөө худаг болон уурхайгаас адил зайд байрлах өөр нэг худгийн усыг тогтмол хэмжиж эхлэв. Сар бүрийн эхний 10 хоногт хоёр худгийнхаа усыг хэмжсээр хэдийнээ гурван жилийн нүүр үзжээ. Энэ хугацаанд аль ч худгийнх нь ус татарсангүй. Одоо тэрээр ХОБОМ үргэлжлэн хэрэгжих эсэхээс үл хамааран худгийн усаа өөрөө байнга хэмжиж байна хэмээн ярьж байна. Тэр бүү хэл уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг хөрш зэргэлдээх багийн иргэд Х-г худгийн усаа хэмжиж өгөөч гэх болжээ. Харин Х тэдэнд ХОБОМ-ийн ажилд өөрсдөө оролцох нь хэчнээн чухлыг уйгагүй ярьж таниулдаг.

Уул уурхайгаас болж худгийн ус татарч, ширгэж байна гэх нь байнга гардаг маргааны нэг юм. Уурхайг хардаж, усаа харамладаг мянга мянган малчны нэг нь ХОБОМ-д оролцсоноор гарсан сайн үр нөлөөний нэг жишээ энэ. Үүнтэй адил ХОБОМ-ийг хэрэгжүүлснээр нөлөөллийн бүсийн иргэд, сумын захиргаа, компани хооронд ойлголцол бий болж, хамтран ажиллаж, хамтын оролцоотойгоор байгаль орчны хяналтаа хийж яваа жишээ цөөнгүй бий.



Зураг 11. ХОБОМ-ийн хорооны хурал, Баяндун сум, 2022 он

Тэдний нэг нь Дорноговь аймгийн Айраг сумын ХОБОМ багийн түүх. БНХАУ-ын хөрөнгө оруулалттай жоншны “Мин Ли Да” компани дээр амжилттай хэрэгжиж буй ХОБОМ эхлэхдээ тийм ч амар хялбар байсангүй. 2020 оны зургаадугаар сард “Эх орон хамтын хүч” ТББ-ын ажилтнууд болон орон нутгийн захиргаа, нөлөөллийн бүсийн малчид ХОБОМ-ийн сургалтад суужээ. Тэд ХОБОМ хэрэгжүүлэх уурхайгаар тухайн үедээ байгаль орчин, нийгмийн асуудлаар нутгийн иргэд, малчидтай ихээхэн зөрчилдөөнтэй байсан “Мин Ли Да” компанийг сонгосон байна. БНХАУ-ын компани гэхээр хариуцлагагүй, хаалттай, үл бүтэх нөхөд гэх нийтлэг ойлголт малчдад байдаг. Анхны уулзалт хардлага сэрдлэг, уурлаж бухимдах гээд хамтрах нь бүү хэл ойлголцоход ч бэрх нөхцөлд болж. Гэхдээ зөвлөлдөх уулзалтыг бэлтгэлээ сайтар базааж, зөв зохион байгуулсны хүчинд эцэстээ зөвшилцөж чадсан байна.

Өдгөө “Мин Ли Да” компанийн уурхай дээр 3 жил ХОБОМ хэрэгжиж байгаа бөгөөд 25 хүн 20 шахам удаагийн сургалтад хамрагдаж, 14 удаагийн хэмжилтээр ургамал, хог хаягдал, химийн бодис, гүний усны мониторинг хийж, мэдээллийн сан үүсгээд байна. Хамгийн гол нь “Мин Ли Да” компани орон нутгийн иргэдтэй хамтран ажиллаж, БОМТ-нд иргэдийн саналыг тусгахаас гадна иргэдийн саналаар малчдын бэлчээр нутагт бичил уурхайн эдэлбэрт өртөж орхигдсон 3.2 га талбайд нөхөн сэргээлт хүртэл хийсэн байна. Иргэдийн гаргах гомдол ч эрс буурсныг ХОБОМ-ийн үр өгөөж хэмээн сумын иргэд онцолж байна.

“Хил хязгааргүй алхам” ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан:

Уул уурхайн салбарт орон нутгийн иргэд хэрхэн хяналт тавих, асуудал гарлаа гэхэд хэрхэн шийдвэрлэх талаар ямар ч ойлголт байдаггүй. Иргэдийн хувьд компани болон сумын захиргаанаас өгсөн мэдээлэлд итгэдэггүй. Иймд иргэд өөрсдөө гар бие оролцож ХОБОМ хийснээр бодит үнэнийг мэдэх, ямарваа асуудал зөрчил гарлаа гэхэд хамтраад шийдэж болдог жишиг тогтож байна” хэмээн ярилаа.

Уул уурхайн салбарын нэр хүндийг хамгийн их унагадаг, итгэлцэл үүсдэггүй, төслийг гацаадаг асуудлын нэг нь байгаль орчны хариуцлага. Байгаль орчны асуудал хүн бүрийн нүдэнд ил мэт харагдавч учир шалтгааныг олох, үнэн худлыг мэдэхэд мэдлэг, чадвар хэрэгтэй. ХОБОМ бол энэхүү дутагдаж буй орон зайд амжилттай хэрэгжиж буй хөтөлбөр юм.

ХОБОМ хэрэгжүүлсэн гурван жилийн хугацаанд нөлөөллийн бүсийн иргэд хууль, эрх зүйн мэдлэгтэй болж, мониторингийн аргачлалд суралцахын зэрэгцээ байгаль орчны өөрчлөлтийн талаар өөрсдийн хэмжиж тэмдэглэсэн их хэмжээний өгөгдөл мэдээлэлтэй болж байна. Хамтдаа судалж, хамтдаа хийж, нэг мэдээлэл, нэг ойлголттой болсон болохоор үл ойлголцол, хардалт сэрдэлт үгүй болдог аж. Цаашид ХОБОМ-ийг бүх л уурхайнуудад хэрэгжүүлэх боломжтой гэсэн итгэл төрснөө Н.Баярсайхан нуугаагүй.

ХОБОМ-ийг хэрхэн үргэлжлүүлэх талаар тодорхой санал, санаачилгууд ч гарч байгаа аж. Тухайлбал, уул уурхайн компани болгон сум, орон нутагтай Хамтын ажиллагааны гэрээ байгуулдаг. Уг гэрээнд ХОБОМ-ийг хамтран хэрэгжүүлэх заалт тусгавал компани, засаг захиргаа, нөлөөллийн бүсийн иргэд бүгдэд нь ашиг тустай юм. Ийм гарц гаргаж, шийдсэн шийдэл ч бий. Завхан аймгийн Дөрвөлжин суманд үйл ажиллагаа явуулдаг “Баян-Айраг Эксплорэйшн” компанийн уурхайд ХОБОМ хэрэгжүүлдэг баг нь компани болон сумын удирдлагатай маш сайн ойлголцож, ХОБОМ-ийг амжилттай хэрэгжүүлж байна. Тус баг Сумын захиргаа болон компани хооронд байгуулдаг “Хамтын ажиллагааны гэрээ”-нд “ХОБОМ-ийг нутгийн иргэдийн оролцоотой тогтмол хэрэгжүүлэх” гэдэг заалтыг байгаль орчны талаар хүлээсэн үүрэг болгон оруулахаар тохиролцож, идэвхтэй ажиллаж байгаа аж.

НҮБХХ-ийн Байгаль орчны засаглал төслөөс хэрэгжүүлсэн ХОБОМ төсөл амжилттай хэрэгжиж, түүний хэрээр уул уурхай ба орон нутгийн ойлголцол бий болж байна. Тиймээс БОЗ төслөөс 2023 онд “Онон Улз голынхон” хөдөлгөөн, “Баян саран гумуда”, “Туна тэргэл сан”, “Эх орон хамтын хүч”, “Говийн хөх салхи”, “Сараана байгаль хамгаалах сан” гэсэн 6 ТББ-д ХОБОМ хийх тэтгэлэг өгөөд байна.

ХОБОМ-ийн арга туршлагыг хэрэгжүүлж, түгээн дэлгэрүүлэхэд мэдлэг, арга зүйн дэмжлэг зөвлөмж шаардагдах нь зүйн хэрэг. Тийм болохоор цаашид талуудын оролцоог хангах, эвлэрүүлэн зуучлах, мэдлэг арга зүйд сургах зөвлөхүүдийн хэрэгцээ шаардлага шинээр үүсэж байна.

4.5 Кейс судалгаа 5:

Монгол Улсад нийгмийн нөлөөллийн үнэлгээг олон улсын жишгээр хийж эхэллээ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль эрхзүйн орчныг боловсронгуй болгон, дэд бүтцийн төсөлд нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх эрхзүйн орчныг бий болгосон нь

Монгол Улсад хэрэгжих аливаа төслүүдэд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх эрх зүйн орчныг 1998 онд анх баталж, 2012 онд шинэчлэн найруулсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБҮ)-ний тухай хууль болон уг хуулийг дагаж гарсан холбогдох журмуудаар зохицуулж иржээ. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБҮ)-ний журамд нийгмийн нөлөөллийн үнэлгээний асуудал хэт ерөнхий тусгагдсан байдаг.

Иймд НҮБХХ-ийн Байгаль орчны засаглал төслийн дэмжлэгтэйгээр Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ) нь нийгмийн нөлөөллийн үнэлгээг олон улсын чиг хандлага, жишигт нийцүүлсэн холбогдох өөрчлөлтийг БОНБҮ-ний журамд шинээр оруулжээ. Шинэчилсэн журам 2023 оны хоёрдугаар сард Засгийн газрын 58 дугаар тогтоолоор батлагдан хэрэгжиж эхлээд байна.


Ингэснээр дэд бүтцийн томоохон төслүүдийн нөлөөллийг олон улсын жишгээр нийгэм, хүний эрх, орон нутгийн эрх ашгийн үүднээс авч үзэх болж байна. Үүний гол ач холбогдол нь зохицуулагдаагүй харилцаанаас үүдэлтэй гардаг элдэв зөрчил маргаан цэгцрэх боломжтой болж байгаа юм.

Байгаль орчны судлаач, доктор И.Бямбахуу:

“Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний явцад байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг үнэлээд зогсохгүй нийгэмд үзүүлж болзошгүй нөлөөлөл, тэдгээрийн харилцан үйлчлэлийг цогцоор судлах, үнэлэхэд энэхүү өөрчлөлт ихээхэн ач холбогдолтой юм.

Нийгмийн нөлөөллийн үнэлгээг нарийвчлан авч үзснээр төслийн үйлжиллагаанаас үүдэн нийгмийн харилцаанд шинээр үүсэж болзошгүй эерэг, сөрөг нөлөөлөл, түүний үр дагаврыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлох, таамаглах, үнэлэх, улмаар сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээг бодитойгоор төлөвлөхийн зэрэгцээ эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх боломжийг судлах бололцоо нээгдэнэ. Мөн нөлөөллийн үнэлгээний явцад шууд болон шууд бусаар өртөж болзошгүй орон нутгийн иргэдийн оролцоо нь олон талт хэлбэрээр илүү өндөр түвшинд хангагдаж, ингэснээр нийгэмд үзүүлж болзошгүй эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлох, таамаглах, үнэлэх үе шатуудад иргэд өөрсдийн санал бодол, байр сууриа илүү бодитоор тусгах боломж бүрэлдэх юм. Үүний зэрэгцээ тухайн төсөлтэй холбоотой мэдээллийн ил тод байдал нэмэгдэнэ. Энэ нь төслийн ил тод байдлыг сайжруулах, улмаар төсөл хэрэгжүүлэгч болон оролцогч талууд, тухайлбал төслийн шууд нөлөөлөлд өртөх орон нутгийн иргэд хоорондын үл ойлголцлыг төсөл хэрэгжих бүхий л хугацаанд багасгахад чухал ач холбогдолтой болно гэж харж байгаа.

Шинэчилсэн журамд төслийн нөлөөллийн бүс дэх иргэдийн оролцоог хангах замаар санал бодол, зөвлөмжийг нь нарийвчлан судлах, нүүлгэн шилжүүлэлт, шинэ газарт дасан зохицох, өрхийн орлого тогтвортой хадгалагдах нөхцөл, нөхөн олговор, гомдол барагдуулах механизм, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гээд өмнө зохицуулалтгүй байсан олон асуудлыг тодорхой авч үзэж, дэлгэрэнгүй тусгажээ.



Зураг 12. БОНБУ хуулийн ажлын хэсгийн хуралдаан, 2022 он


Цаашлаад БОАЖЯ-наас баталсан нийгмийн нөлөөллийн үнэлгээний баримт бичиг олон улсад хүлээн зөвшөөрөгдөх давхар ач холбогдолтой юм. Тодруулбал, энэхүү өөрчлөлт хийгдэхээс өмнө томоохон төслүүдэд БОНБУ-ний журмын дагуу нийгмийн нөлөөллийн асуудлыг тусгахаас гадна олон улсын банк санхүүгийн байгууллагаас тавигддаг стандартаар тусдаа бас нэг үнэлгээ хийгддэг байв. Нэг ёсондоо зэрэгцээ хоёр нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийдэг байсан нь нэг болсноор төсөл хэрэгжүүлэгчдийн хувьд ч гэсэн цаг хугацаа, хөрөнгө хүч хэмнэсэн үр ашигтай өөрчлөлт болж байна.

БОАЖЯ-ны Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн дарга Г.Энхмөнх:

Журам, аргачлалыг шинэчилсэн нь олон улсын чиг хандлагатай нийцүүлсэн дэвшилтэт алхам. Одоо энэхүү нийгмийн нөлөөллийн үнэлгээтэй холбоотой асуудлыг Байгаль орчны нарийвчилсан нөлөөллийн үнэлгээний тухай хуульд тусгах нэмэлт өөрчлөлт хийгдэж байгаа. Хууль эрхзүйн орчиндоо буюу одоо мөрдөгдөж байгаа хуульд журам батална, журамд байгаль орчин, нийгмийн нөлөөлөлтэй холбоотой асуудлыг тусгана гэсэн зохицуулалттай. Энэ ерөнхий зохицуулалтыг хуулиар илүү тодорхой болгож өгч байгаа.

Шинэ журам, аргачлалын дагуу нийгмийн нөлөөллийн үнэлгээг дэд бүтцийн том төслүүд дээр хийж эхэлсэн ба эхний сайн туршлагууд гарч байна. Журам, аргачлал боловсруулах шатанд хийгдсэн Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, АНУ-ын Мянганы сорилтын сангийн тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл” болон шинэ журмын дагуу хийгдсэн “Дарханы арьс ширний үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах” төслийн нийгмийн нөлөөллийн үнэлгээ нь бусад төслийн хувьд жишиг туршлага болохуйц сайн хийгдсэн гэж үнэлэгдэж байна.

Нийгмийн нөлөөллийн үнэлгээг олон улсын жишгээр нарийвчлан зохицуулах болсон нь байгаль орчныг хамгаалах төдийгүй хүний эрхийг хангахад манай улсын хувьд чухал ахиц дэвшил юм. Гэхдээ журам, аргачлалтай болсноор бүх асуудал шийдэгдэхгүй. Бүрэн дүүрэн, үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хэрэгжилтийг дэмжих ажлын шаардлагууд шинээр үүсэж байна. Тухайлбал, боловсон хүчнийг мэргэшүүлэх, холбогдох мэргэжилтнүүдийг сургаж чиглүүлэх, нийгмийн нөлөөллийн үнэлгээний ач холбогдлыг танин мэдүүлэх, зөв ойлголт өгөх зэрэг асуудлууд тулгарч байна.



Зураг 13. БОНБҮ хуулийн ажлын хэсгийн хуралдаан, 2022 он

БОАЖЯ-ны Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн дарга Г.Энхмөнх:

Хууль эрх зүйн орчинд бий болсон энэхүү чухал зохицуулалтыг амьдралд бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудал гэвэл нийгмийн нөлөөллийн үнэлгээний талаарх зөв ойлголтыг нийгэмд төлөвшүүлэх, нэгдмэл ойлголттой болгох явдал чухал байна. Нөлөөллийн үнэлгээний хэрэгжилт, гүйцэтгэлийг тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-гөөр хянадаг. БОНБУ-ний журмаар бол БОМТ-ний хэрэгжилтийг газар дээр нь шалгаж дүгнэлт өгөх үүрэг бүхий Ажлын хэсгийг тухайн орон нутгийн Засаг даргын шийдвэрээр байгуулдаг. Энэ ажлын хэсэгт байгаль орчин, хөгжлийн бодлогын мэргэжилтнүүдээс гадна орон нутаг дахь төрийн байгууллагуудын төлөөлөл ордог тул тэдгээр хүмүүст нийгмийн нөлөөллийн үнэлгээг зөвөөр ойлгуулах хэрэгцээ шаардлага их байна.

Мөн нөгөө талдаа БОНБУ хийж байгаа мэргэжлийн байгууллагуудаа зөв чиглүүлэх, олон улсын чиг хандлагыг таниулах, цаашлаад нийгмийн нөлөөллийн үнэлгээтэй холбоотой сайн туршлагыг жишиг болгож танилцуулах, харилцан туршлага солилцох, ингэснээр нийгмийн нөлөөлөлтэй холбоотой зөрчлийн асуудлыг хэрхэн шийдэж байгааг бодитоор таниулбал хэрэгжилт илүү үр дүнтэй болно.

Журмын хэрэгжилтийг дэмжихтэй холбоотойгоор БОАЖЯ-наас үнэлгээний мэргэжлийн байгууллагууд болон уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд 2023 онд хэд хэдэн удаагийн сургалт хийгээд байна. Мөн БОНБНҮ-г хянаж хэлэлцдэг БОАЖЯ-ны дэргэдэх Мэргэжлийн зөвлөлийн гишүүд, аймаг, нийслэлийн Байгаль орчны газрын мэргэжилтнүүдэд энэ чиглэлээр тодорхой мэдээлэл өгч, чадавхжуулах сургалтыг үе шаттайгаар зохион байгуулжээ. Түүнчлэн нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх болон нөлөөлөлд өртөж буй иргэдийн нийгмийн асуудлаар мэргэшсэн боловсон хүчин Монголд харьцангуй дутмаг байгаа тул БОАЖЯ-ны зүгээс энэ чиглэлийн боловсон хүчин бэлтгэх, мэргэшүүлэх асуудлыг холбогдох газруудад тавьж, судалж байгаа аж.

Нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх суурь нөхцөлийг ийнхүү журам, аргачлалаар тодорхой болгож өгсөн нь цаашид томоохон төслүүдэд байгаль орчны нөлөөллийн үнэлгээг боловсруулах ажлын хүрээнд нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх үндэсний хэмжээний арга зүйг боловсруулахад чухал дэмжлэг болох юм.

5. ДҮГНЭЛТ



5.1 Сургамж, хүндрэл бэрхшээл

- КОВИД-19 цар тахлын дэгдэлтийг хязгаарлах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас тогтоосон хязгаарлалтын дэглэм, хөл хорионы улмаас 2020-2021 онд хот, хөдөө орон нутгийн оролцогч талуудтай харилцах үндсэн ажлууд хойшлогдож, зарим нь цуцлагдах нөхцөл байдал үүссэн байна.
- Одоогоор Монгол Улс хүний эрхийн бодлого, хэрэгжилтийн тогтолцоогоо КОВИД-19 цар тахал, уур амьсгалын өөрчлөлт болон дижитал шилжилттэй уялдуулан урт хугацааны хөгжлийн бодлогодоо нийцүүлэн шинэчлэн тодорхойлохоор ажиллаж байна.
- Хөтөлбөрийн үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд бусад олон улсын байгууллага болон хандивлагч орнуудын ижил төстэй зорилго бүхий төслүүдтэй хамтран ажиллах хүчин чармайлт, хамтын ажиллагаа нэн чухал юм.

5.2 Дүгнэлт

- БОЗ төслөөс хэрэгжүүлсэн хариуцлагатай уул уурхайн стандарт, хэм хэмжээг төлөвшүүлэх, хамтын оролцоотой байгаль орчны мониторинг, нөхөн сэргээлтийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, жишиг үйл ажиллагааг турших, хүний эрхийг хүндэтгэх, хэм хэмжээг дагаж мөрдөхөд чиг удирдамж болох арга аргачлал, гарын авлага, заавар журмуудыг боловсруулан практикт нэвтрүүлснээр компаниудыг тогтвортой үйл ажиллагаанд чиглүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн байна.
- БОЗ төсөл нь төрийн байгууллага, иргэний нийгэм, хувийн хэвшлийн компаниуд зэрэг голоролцогч талуудтай нягт хамтран ажиллаж, байгаль орчны засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн хууль эрхзүйн орчин, хэрэгжилтийн механизмыг сайжруулахын тулд хууль эрх зүйн орчинд үнэлэлт дүгнэлт өгч, зохицуулалтыг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлж ажилласан байна.
- БОЗ төсөл нь шинэ журам, арга аргачлалыг практикт нэвтрүүлэхийн тулд гарын авлага, сургалтын модуль боловсруулахын зэрэгцээ үзүүлэх сургалт, жишиг үйл ажиллагаатай танилцуулах байдлаар туршлага солилцох, түгээн дэлгэрүүлэх ажлыг амжилттай хэрэгжүүлсэн байна.
- Уул уурхайн салбарт байгаль орчны засаглалыг бэхжүүлэх болон хүний эрхийг хамгаалахад орон нутгийн иргэд, ялангуяа эмэгтэйчүүд томоохон үүрэг гүйцэтгэж чадахыг БОЗ төслийн хэрэгжүүлсэн ажлууд харуулж байна.

5.3 Зөвлөмж

- Хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангаж, үр нөлөөтэй хэрэгжүүлэх үндсэн зорилгын хүрээнд уул уурхайн салбарт байгаль орчны засаглалыг бэхжүүлэхийн тулд хууль, эрх зүйн орчныг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаагаа цаашид тууштай үргэлжлүүлэх нь зүйтэй. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, холбогдох журмыг шинэчлэн боловсруулах зэргээр эрх зүйн зохицуулалт хийснээр үүнийг хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.
- Иргэний нийгмийн байгууллагуудад дэмжлэг үзүүлэх замаар уул уурхайн бүс нутгуудад Хамтын оролцоотой байгаль орчны мониторинг (ХОБОМ)-ийн механизмыг институцчилах шаардлага бий. Энэхүү стратеги нь уул уурхайн салбарт ХОБОМ загварыг дэмжин хэрэгжүүлэгч оролцогч талуудын тоог нэмэгдүүлэх замаар уул уурхай ба орон нутгийн зөрчлийг бууруулах, хамтын оролцоог сайжруулахад чухал хувь нэмэртэй юм.
- Хөтөлбөрийн хамрах хүрээг уул уурхай, уур амьсгалын өөрчлөлт, ойн аж ахуй зэрэг салбаруудыг хамруулан өргөжүүлэх нь чухал. Үүнийг “Нөхөн сэргээлт-2024” санаачилга, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн зэрэг үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөрүүдтэй нийцүүлж, уялдуулахыг зөвлөж байна. Энэхүү хамтарсан арга хэмжээ нь байгаль орчны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд илүү өргөн хүрээтэй, нэгдсэн нөлөө үзүүлэхэд чухал хувь нэмэр оруулна.
- Байгаль орчны засаглал төсөлд хамрагдаж буй бусад улс орнуудтай хамтран ажиллах, бүс нутгийн түншлэлийг дэмжих нь сайн туршлага судлах, харилцан суралцахад чухал ач холбогдолтой. Энэхүү хамтын хүчин чармайлт нь байгаль орчны засаглалыг бэхжүүлэх, хууль сахиулах, уурхайн нөхөн сэргээлт, хүний эрхийг харгалзан үзэх, жендэрийн оролцоог хангахад чиглэж болно. Бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд шилдэг сайн туршлагыг хуваалцсанаар байгаль орчныг хамгаалах санаачилгын үр нөлөөг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.

5.4 Төслийн дараагийн шатанд өгөх зөвлөмж

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Байгаль орчны засаглал” хөтөлбөрийн хүрээнд эрдэс баялгийн салбарын засаглал, хөгжил, төлөвшилд чухал хувь нэмэртэй шинэлэг төсөл, хөтөлбөр цөөнгүйг хэрэгжүүлээд байна. Тухайлбал, Хүний эрхэд нөлөөлөх байдлын магадлан шинжилгээ хийх аргачлалыг эрдэс баялгийн салбарын уул уурхайн олборлох компаниудад нэвтрүүлэх, Хариуцлагатай уул уурхайн жишиг шаардлага ба үнэлэх аргачлал боловсруулах, Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон газарт нөхөн сэргээлтийн аргачлал боловсруулан, нэвтрүүлэх, Хамтын оролцоотой байгаль орчны мониторингийг түгээн дэлгэрүүлэх, Дэд бүтцийн төсөлд нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх эрхзүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хэрэгжүүлсэн төслүүдийг нэрлэж болно.

Эдгээр цоо шинээр нэвтрүүлж буй арга аргачлалуудын хувьд сурталчлан таниулах сургалт, сурталчилгааны ажлуудыг түлхүү хийн, холбогдох бодлого үйл ажиллагаатай уялдуулан салбарын хэмжээнд түгээн дэлгэрүүлэх нь чухал юм.

Тухайлбал, 2007 оноос хойш хэрэгжүүлсэн нөхөн сэргээлтийн талаарх үзүүлэх сургалтууд, жишиг нөхөн сэргээлттэй танилцуулах арга хэмжээнүүд, харилцан туршлага солилцох, тэдгээрийг түгээн дэлгэрүүлэх мэдээлэл сурталчилгааг идэвхжүүлсний үр дүнд нийгэмд нөхөн сэргээлтийн талаар нэгдмэл ойлголт, техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ялгааг ойлгодог зөв мэдлэг хандлага нийгэмд төлөвшин тогтсон билээ.

Түүн шиг ХОБОМ, ХЭМШ, нийгмийн нөлөөллийн үнэлгээ зэрэг шинэлэг ойлголтуудтай холбоотой асуудлаар зөв мэдлэг ойлголт төлөвшүүлэх, орон нутаг дахь албан хаагчдыг мэдлэг, ойлголттой болгох, соён гэгээрүүлэх чадавхжуулах сургалтын үйл ажиллагаа, мэргэжлийн байгууллагуудыг зөв чиглүүлэх, олон улсын чиг хандлагыг таниулах, сайн туршлагауудыг жишиг байдлаар танилцуулах, харилцан туршлага солилцох мэдээлэл сурталчилгааны ажлыг хэрэгжүүлэх болон дэмжиж ажиллавал шинээр боловсруулсан арга аргачлалуудын үр дүнтэй хэрэгжүүлэх, хүртээмжтэй түгээн дэлгэрүүлэхэд үр дүнтэй юм.

Монгол Улсад олон талт болон 2 талт хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд техникийн туслалцааны төслүүд 2010 оноос Уул уурхайн салбарт эрчимтэй хэрэгжиж эхэлсэн. 2024 оны 1 дүгээр сарын байдлаар энэ чиглэлийн Швейцар, Канад, Австрали улсуудын хөгжлийн хамтын ажиллагаа дуусаж, Дэлхийн банкны ОУИТБС-ын хэрэгжүүлэн олборлох салбарын ил тод байдлыг бэхжүүлэх төсөл, Германы хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд BGR-ийн Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ төсөл, шинээр Азийн хөгжлийн банкны Climate-Smart Mining төсөл хэрэгжиж байна.

Уул уурхайн салбар нь Монгол орны эдийн засагт голлох байр суурьтай хэвээрээ, бүх шатны төсвийн орлогот эзлэх хувь өсөж, байгаль орчны болон нийгмийн нөлөөлөл цаашид өсөхөөр байна. Мөн Монгол Улсын Засгийн газраас уул уурхайн хайгуул, олборлолт, боловсруулалтын үйл ажиллагааг нэмэгдүүлэх бодлого баримтлан ажиллаж байна. Иймд эрдэс баялгийн салбарын тогтвортой хүртээмжтэй хөгжлийг дэмжих, сайн засаглалыг бэхжүүлэхэд дараах чиглэлд зайлшгүй анхаарал хандуулан ажиллах шаардлагатай байна. Дээр дурдсан одоо хэрэгжиж байгаа төслүүд дараах үйл ажиллагаатай давхцахгүй болно.

- Уул уурхайн орлогын менежмент (хуваарилалт, зарцуулалт)
- Төсөв болон орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтыг уул уурхай бүхий орон нутгийн түвшинд зохистой удирдах чадавхыг бэхжүүлэх
- Уул уурхайн салбарын нүүрс төрөгчийн ялгарал, Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хувь нэмрээ оруулах
- Талуудын хамтын ажиллагаа, түншлэлийг орон нутгийн түвшинд бэхжүүлэх арга хэрэгслүүдийг турших
- Иргэдийн оролцоо, хүний эрхийг хангах, уул уурхайн салбарын олон талт засаглалыг бэхжүүлэх
- Чухал ашигт малтмалын хайгуул олборлолтын бодлого төлөвлөлтийг тогтвортой хөгжлийн зорилттой уялдуулах

Хавсралт 1.

БОЗХ-ийн хүрээнд хийгдсэн судалгаа, үнэлгээний ажлын жагсаалт

Нэр	Он	Линк
1 БОНБУ-ний тогтолцоо, түүнийг хэрэгжүүлэх механизмын бүтээмжийн үнэлгээ	2020	https://www.undp.org/mongolia/publications/desk-review-eia-review-and-approval-procedure
2 Бизнес ба Хүний эрх үндэсний суурь үнэлгээ	2020	https://www.undp.org/mongolia/publications/national-baseline-assessment-business-and-human-rights
3 Хүний эрхийн магадлан шинжилгээ ба Ковид-19 Бизнесийн байгууллагын өөрийгөө үнэлэх түргэвчилсэн тест	2021	https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/publications/UNDP-RBAP-2020-Human-Rights-Due-Diligence-and-COVID-19-Update-2021-MNG.pdf
4 “Эмэгтэйчүүд ба уул уурхайн ирээдүй” судалгаа	2022	https://www.iisd.org/system/files/2023-04/women-mine-of-the-future-mongolia.pdf

Хавсралт 2.

БОЗ төслийн хүрээнд боловсруулан гаргасан гарын авлага, аргачлал, сургалтын материалууд

Дд.	Нэр	Хэрэглэгч	Он	Линк
1	“Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтад хүний эрх, хууль дээдлэх зарчмыг хангах нь” гарын авлага	Мэргэжлийн хяналтын улсын байцаагч нар	2020	https://www.undp.org/mongolia/publications/guideline-inspection-environmental-law-violations-and-enforcement-law-offence
2	Уурхайн хаалт болон байгаль орчны менежмент-ийн төлөвлөгөө цахим хичээл-гарын авлага	Уул уурхайн салбарын бүх оролцогч талууд	2020	https://www.youtube.com/watch?v=xnyeSSxMz6w
3	“Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ” гарын авлага	ХЭҮК, Тавантолгойн бүлэг орд	2021	https://www.undp.org/mongolia/publications/khuniy-erkhed-noloolokh-baydlyn-unelgee
4	НҮБ-ын Бизнес ба Хүний эрхийн удирдах зарчмууд	ГХЯ	2020	https://www.undp.org/mongolia/publications/nub-yn-biznes-ba-khuniy-erkhiyn-udirdakh-zarchmuud
5	Бизнес ба Хүний эрх” видео танилцуулга	ГХЯ	2020	https://www.youtube.com/playlist?list=PLMVO_7rytXgv5vSIDtLfcAt9kf5P3yt4Z

6	“Хамтын оролцоотой байгаль орчны мониторинг” гарын авлага	Хил хязгааргүй алхам ТББ	2021	https://www.undp.org/mongolia/publications/khamtyn-oralcootoy-baygal-orchny-monitoring-garyn-avлага
7	“Хариуцлагатай уул уурхайн кодекс” сургалтын материал	МУУҮА	2021	https://www.miningmongolia.mn/page/
8	“Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон газарт нөхөн сэргээлт хийх аргачлал”	МХЕГ	2021	https://legalinfo.mn/detail?lawId=16531276372281
9	Хүний эрхийн магадлан шинжилгээ ба Ковид-19 Бизнесийн байгууллагын өөрийгөө үнэлэх түргэвчилсэн тест	ГХЯ	2021	https://www.facebook.com/watch/?v=938144010628216&ref=sharing
10	ХОБОМ-ийн шинэчилсэн гарын авлага	Хил хязгааргүй алхам ТББ	2024	https://www.undp.org/mn/mongolia/publications/khamtyn-oralcootoy-baygal-orchny-monitoring-garyn-avлага

Хавсралт 3

БОЗХ-ийн үйл ажиллагааны тайлангууд

Дд.	Тайлангийн нэр	Линк
1	БОЗХ-ийн 2020 оны үйл ажиллагааны тайлан	https://www.undp.org/mongolia/publications/sepa-annual-report-2020
2	БОЗХ-ийн 2021 оны үйл ажиллагааны тайлан	хэвлэсэн
3	БОЗХ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайлан	хэвлэсэн
4	БОЗХ-ийн 2023 оны үйл ажиллагааны тайлан	хэвлэсэн

